УСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ЫН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ТАЙЛАН

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэхүү Усны тухай хууль-ийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандсан судалгааг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлсан “Хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу боловсруулав.

Судалгааны зорилго нь усны нөөцийн хамгаалалт, ашиглалт, сав газрын нэгдсэн менежмент, газрын доорх усны хамгаалалт, усны аюулгүй байдал, ус ашиглалтын хяналт, усны мэдээллийн тогтолцоо, усны эдийн засгийн зохицуулалт болон усны салбарт тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, Усны тухай хууль-ийн шинэчилсэн найруулга боловсруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тогтоох, түүнчлэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үндэслэлийг тодорхойлоход оршино.

Монгол Улсын усны хэрэглээний 80 орчим хувийг газрын доорх усаар хангаж байгаа нь газрын доорх усны нөөцөд өндөр дарамт учруулж, цаашид усны нөөцийн хомсдол, эх үүсвэрийн доройтол бий болох эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Мөн уул уурхай, боловсруулах үйлдвэр, эрчим хүч, газар тариалангийн салбарын хөгжилтэй холбоотойгоор ус ашиглалтын хэмжээ нэмэгдэж, усны бохирдол, усны эх үүсвэрийн доройтол, хаягдал ус, ус ашиглалтын хяналт, усны төлбөрийн тогтолцоо, усны хамгаалалтын бүсийн хэрэгжилт зэрэг асуудал практикт тулгамдсан хэвээр байна.

УСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ЫН ТӨСЛИЙН УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “усны нөөц төрийн нийтийн өмч мөн” гэж тус тус заасан байдаг. Иймд усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, иргэдийн аюулгүй, хүртээмжтэй ундны ус хэрэглэх эрхийг хангах нь төрийн үндсэн үүргийн нэг юм.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, төрөөс баримталж буй байгаль орчин, усны нөөцийн бодлогын баримт бичгүүдэд усны нөөцийн хомсдолоос сэргийлэх, усны үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэх, усны нөөцийг хамгаалах, ус дахин ашиглалтыг дэмжих, усны аюулгүй байдлыг хангах талаар тусгасан байна.

Түүнчлэн Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-

д Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах асуудлыг тусгасан байна.

Усны тухай хуулийг 2012 онд шинэчлэн баталснаас хойш олон удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч усны нөөцийн хамгаалалт, усны аюулгүй байдал, газрын доорх усны ашиглалт, сав газрын нэгдсэн менежмент, усны дата, усны мониторинг, ус дахин ашиглалт зэрэг орчин үеийн шинэ төрлийн харилцааг бүрэн зохицуулж чадахгүй байна.

1.1. Усны харилцааны талаарх эрх зүйн зохицуулалт

Монгол Улс 2012 онд Усны тухай хуулийг баталсан бөгөөд 5 удаа нэмэлт, өөрчлөлт, 6 удаа шинэчилсэн найруулга оруулсан байна. Мөн Монгол Улс Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын суурь конвенц, Биологийн олон янз байдлын тухай конвенц, Ган цөлжилт ноцтой нэрвэгдэж буй орнуудын болон ялангуяа Африкийн цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц, Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенц, Озоны үе давхаргыг хамгаалах тухай конвенц, Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенц, Байгаль орчинд нөлөөлөх арга хэрэгслийг цэргийн буюу дайсагнах бусад аливаа зорилгоор ашиглахыг хориглох тухай конвенц, Далайн навигацийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц болон эх газрын хормойд байрлуулсан суурилуулах төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай протоколд нэгдэн орсныг соёрхон батлах тухай, Хөлөг онгоцны тэнцвэржүүлэгч ус болон үлдэгдэл тунадасны хяналт ба менежментийн тухай, Хилийн усыг хамгаалах болон ашиглах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад ард улсын засгийн газар хоорондын хэлэлцээр, Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын засгийн газар хоорондын хэлэлцээрийг тус тус баталсан.

Монгол Улс устай холбоотой харилцааг Монгол Улсын Үндсэн хууль, Авто замын тухай, Байгалийн ургамлын тухай, байгаль орчныг хамгаалах тухай, Газрын тухай /шинэчилсэн найруулга/, Галын аюулгүй байдлын тухай /шинэчилсэн найруулга/, Захиргааны ерөнхий хууль, Зөвшөөрлийн тухай /шинэчилсэн найруулга/, Иргэний хууль, Орон сууцны тухай, Хаягжуулалтын тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай /шинэчилсэн найруулга/, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай, Амьтны тухай /шинэчилсэн найруулга/, Ашигт малтмалын тухай (шинэчилсэн найруулга), Аялал жуулчлалын тухай /шинэчилсэн найруулга/, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай /шинэчилсэн найруулга/, Байгаль орчныг хамгаалах тухай, Барилгын тухай, Газрын төлбөрийн тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай, Газрын хэвлийн тухай, Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Зарим материал, тоног төхөөрөмж, машин механизмыг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай,

Засгийн газрын тусгай сангийн тухай, Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/, Зөрчлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга/, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай /шинэчилсэн найруулга/, Монгол Улсын Засгийн газрын тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Монгол Улсын Их Хурлын тухай /шинэчилсэн найруулга/, Монгол Улсын төрийн ордны тухай, монгол улсын хилийн тухай /шинэчилсэн найруулга/, Ойн тухай /шинэчилсэн найруулга/, Органик бүтээгдэхүүний тухай /шинэчилсэн найруулга/, Соёлын өвийг хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/, Статистикийн тухай /шинэчилсэн найруулга/, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай, зарим зүйл заалтыг тайлбарлах тухай Сэргээгдэх эрчим хүчний тухай, Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн хэмнэлтийн тухай, Төсвийн тухай /шинэчилсэн найруулга/, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай /шинэчилсэн найруулга/, Ус бохирдуулсны төлбөрийн тухай, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Усан замын тээврийн тухай /шинэчилсэн найруулга/ Усны тухай /шинэчилсэн найруулга/, үйлдвэрийг дэмжих тухай, Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай, Хог хаягдлын тухай /шинэчилсэн найруулга/, Хот байгуулалтын тухай /шинэчилсэн найруулга/, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай/шинэчилсэн найруулга/, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай /шинэчилсэн найруулга/, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Чөлөөт бүсийн тухай /шинэчилсэн найруулга/, Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Эрүүл ахуйн тухай, Эрчим хүчний тухай, тус тус хуулиар зохицуулсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 178 дугаар, 2021 оны 10 сарын 04-ний өдрийн 58 дугаар Засгийн газарт чиглэл өгөх тухай зарлиг, 2017 оны 7 сарын 10-ны өдрийн 186 дугаар Нутаг орны газар зүйн нэрийг хамгаалах тухай зарлиг, 2025 оны 04 сарын 03-ны өдрийн 44 дугаар Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай зарлиг, 2017 оны 7 сарын 10-ны өдрийн 183 дугаар Хөвсгөл нуур болон орон нутгийн иргэдийн уламжлал, соёлыг хамгаалах санаачилгыг дэмжих тухай зарлиг, 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 230 дугаар Хархорум хотыг сэргээн байгуулах тухай зарлиг, 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 09 дугаар Үйлдвэржилтийг эрчимжүүлэх талаар засгийн газарт чиглэл өгөх тухай зарлиг, 1991 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 84 дугаар байгаль орчноо ариусган дээдлэх санаачилгыг дэмжих тухай зарлиг, 2007оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 183 дугаар Суварга хайрхан уул, хан хөхий уул, сутай хайрхан уулыг төрийн тахилгатай болгох тухай зарлигийг тус тус гаргасан байна.

Монгол Улсын Их Хурал 2009 оны 07 сарын 16-ны өдрийн 55 дугаар Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоол, 1994 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 32 дугаар Аймаг, сум байгуулах тухай тогтоол, 2001 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 17 дугаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай

хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоол, 2024 оны 06 сарын 05 өдрийн 62 дугаар Ашигт малтмал хайх, ашиглах зориулалтаар газар, түүний хэвлийг тусгай зөвшөөрлөөр олгох, төлбөр, татвар ногдуулах, хураахтай холбоотой үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоол, 2000 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 38 дугаар Байгаль орчны талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоол, 2001 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 17 дугаар Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоол, 2009 оны 07 сарын 16 өдрийн 55 дугаар Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоол, 1996 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 43 дугаар Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай тогтоол, 2019 оны 06 сарын 06 өдрийн 62 дугаар Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоол, 2024 оны 05 сарын 02 өдрийн 37 дугаар Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2023 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай тогтоол, 2024 оны 01 сарын 16 өдрийн Монгол улсын их хурлын хянан шалгах түр хорооноос "Эрдэнэс Таван-толгой" ХК, "Таван-толгой" ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил, үйлчилгээний худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоол, 2024 оны 06 сарын 05 өдрийн 64 дугаар Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай тогтоол, 2019 оны 11 сарын 21 өдрийн 92 дугаар Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай тогтоол, 2020 оны 01 сарын 17 өдрийн 06 дугаар Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоол, 2014 оны 07 сарын 01 өдрийн 48 дугаар УИХ-ын 2014 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай тогтоол, 2022 оны 06 сарын 17 өдрийн 36 дугаар Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоол, 2021 оны 12 сарын 30 өдрийн 106 дугаар Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай тогтоолыг тус тус гаргасан.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 237 дугаар "Гадаргын усны үндсэн үзүүлэлтийг тодорхойлох" /БНБД 33-10-25/ барилгын норм ба дүрэм шинэчлэн батлах тухай” тушаал, Монгол улсын барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 162 дугаар "Усны барилга байгууламжийн буурь" /БНбД 33-04-23/ барилгын норм, дүрмийг шинэчлэн батлах тухай” тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2012 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн А-28 дугаар Аргачилсан заавар батлах тухай /газрын доорх усны нөөцийг хүлээн авах ангилал, зэрэглэл/ тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/59 дугаар “Аргачлал батлах тухай” тушаал, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын тушаал 2010 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 107 дугаар Барилгын норм ба дүрэм батлах тухай / усны барилга байгууламжийн буурь/ тушаал, Монгол улсын дэд бүтцийн сайдын тушаал 2003 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 134 дугаар Барилгын норм ба дүрэм батлах тухай тушаал, Монгол Улсын Зам, тээвэр, барилга,

хот байгуулалтын сайдын 2011 оны 05 сарын 02-ны өдрийн Барилга норм, ба дүрэм батлах тухай тушаал, Монгол улсын байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн А-230/127 дугаар Журам батлах тухай тушаал, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын2013 оны 03 сарын 01-ний өдрийн А-66 дугаар Журам батлах тухай /ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэл тогтоох болон энэ үед мөрдөх усны нөөцийн менежментийн/ тушаал, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаал 2014 оны 3 сарын 17-ны өдрийн А-86 дугаар Журам батлах тухай /улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх/ тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/406/226 дугаар Журам, аргачлал батлах тухай тушаал, Эрүүл мэндийн сайд, байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2017 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн Дугаар А/333/А/245 дугаар Ундны болон ахуйн усны хоногт шаардагдах зохистой хэмжээг батлах тухай тушаал, Барилга хот байгуулалтын сайдын 2005 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 80 дугаар Барилга засварын ажлын төсвийн суурь норм батлах тухай тушаал, Монгол улсын зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 290 дугаар Барилгын норм ба дүрэм батлах тухай /БНБД81-10-04*10/ тушаалаар тус тус гаргасан байна.

Усны тухай хуулийг 2012 онд шинэчлэн баталж, түүнээс хойш олон удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч усны нөөцийн хамгаалалт, ашиглалт, сав газрын нэгдсэн менежмент, газрын доорх усны хамгаалалт, усны аюулгүй байдал, усны мэдээллийн тогтолцоо болон усны эдийн засгийн зохицуулалттай холбоотой орчин үеийн шинэ төрлийн харилцааг бүрэн зохицуулж чадахгүй байна.

Монгол Улсын усны хэрэглээний 80 орчим хувийг газрын доорх усаар хангаж байгаа бөгөөд уул уурхай, үйлдвэржилт, хотжилт, хүн амын төвлөрөл нэмэгдэхийн хэрээр газрын доорх усны ашиглалт эрчимтэй өсөж байна. Гэвч газрын доорх усны нөөцийн нөхөн сэргэх чадамж, ашиглалтын дээд хязгаар, эрсдэлийн үнэлгээ, хяналт-шинжилгээний тогтолцоо хангалтгүй байгаа нь усны нөөцийн хомсдол, эх үүсвэрийн доройтол үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Түүнчлэн усны нөөцийн хамгаалалт, ус ашиглалт, усны хяналт-шинжилгээ, ус ашиглах зөвшөөрөл, усны мэдээллийн удирдлага, усны хамгаалалтын бүсийн хэрэгжилттэй холбоотой төрийн байгууллагуудын чиг үүргийн давхардал, уялдаа холбоо сул байгаа нь практикт хүндрэл үүсгэж байна. Мөн сав газрын менежментийн тогтолцоо хангалтгүй, усны мэдээллийн нэгдсэн сан болон цахим мониторингийн систем бүрэн хөгжөөгүй, ус ашиглалтын бүртгэл, тайлагнал, усны аудитын тогтолцоо сул байгаа нь усны нөөцийг шинжлэх ухаанд суурилан удирдах боломжийг хязгаарлаж байна.

Уул уурхай, боловсруулах үйлдвэр, эрчим хүч, газар тариалангийн салбарын усны хэрэглээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор усны бохирдол, хаягдал ус, усны эх үүсвэрийн доройтол, ус ашиглалтын үр ашиггүй байдал, усны төлбөрийн тогтолцооны сул зохицуулалт зэрэг асуудал нэмэгдэж байна. Түүнчлэн ус дахин ашиглалт, саарал ус, усны дата, экологийн урсац, усны эрсдэлийн удирдлага зэрэг шинэ төрлийн харилцааны эрх зүйн зохицуулалт тодорхой бус байна.

Мөн уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, хуурайшилт, мөстөл хайлах, хур тунадасны өөрчлөлт зэрэг нь усны нөөцөд сөргөөр нөлөөлж, усны аюулгүй байдал, усны

хүртээмжид эрсдэл учруулж байгаа боловч эдгээр асуудлыг цогцоор нь зохицуулах эрх зүйн орчин хангалтгүй байна.

Иймд усны нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, усны аюулгүй байдлыг хангах, сав газрын нэгдсэн менежментийг хөгжүүлэх, газрын доорх усны хамгаалалтыг сайжруулах, усны мэдээллийн нэгдсэн тогтолцоо, цахим хяналт-шинжилгээ, усны аудит, ус дахин ашиглалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг сайжруулахад оршино.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам захиалгаар 2023 онд гүйцэтгэсэн “Байгаль Орчны Салбарын Хуулиудын Давхардал, Зөрчил, Хийдлийг Арилгах Дүн Шинжилгээ Хийх, Салбарын Хуулиудад Нэмэлт, Өөрчлөлт Оруулах Тухай Хуулийн Төсөл Боловсруулах Судалгаа”-ны тайланд тусгаснаар Усны тухай хуульд заасан захиргааны хэм хэмжээ тогтоосон акт 8, хэрэгжилтгүй хэм хэмжээний 5 байна. Мөн судалгааны тайланд хуулийн давхардал, зөрчил, хийдлийн судалгааны дүнд Усны тухай хууль нь давхардал-0, зөрчил-3, хийдэл-12 гэж тус тус дүгнэлт гаргасан байна.

1.2. Устай холбоотой практикт үүсэж буй шалтгаан

Олон улсын хамтын ажиллагааны хүрээнд манай улс ногоон эдийн засгийг дэмжихийг уриалсан уриалгыг тухай бүр дэмжиж ирсэн байна. НҮБ-ын Ерөнхий Ассемблейн “Рио+20” бага хурлаар “Тогтвортой хөгжил, ядуурлыг арилгах хүрээний ногоон эдийн засаг”, “Тогтвортой хөгжил-Байгаль орчны засаглал, бүтэц зохион байгуулалт” гэсэн хоёр асуудлыг хэлэлцсэн байна. Чуулга уулзалтаар 1992 оны Рио-оос баталсан “Байгаль орчин-Хөгжил” тунхаглал, 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөр, 2002 оны Иоханнесбургийн “Тогтвортой хөгжил”-ийн тунхаглал зэрэг үйл ажиллагааны хөтөлбөрүүд, тогтвортой хөгжлийн зарчмуудын хэрэгжилтийн үр дүнд дүгнэлт хийх, цаашид дэлхийн хүн төрөлхтний хөгжлийг тодорхойлох “Ногоон эдийн засаг” олон улсын бодлогын баримт бичгийг хэлэлцэх, батлах зэрэг ажлыг зохион байгуулсан. Тогтвортой хөгжлийн асуудлаарх НҮБ-ын “Рио+20” бага хурлын төгсгөлийн баримт бичгийн анхны төслийн үр дүнг хэлэлцэх албан бус хэлэлцүүлгийг манай улс дотооддоо хийж саналаа НҮБ-ын төлөөлөгчийн газарт хүргүүлж, 77–гийн бүлгээр хэлэлцүүлэн, Ногоон эдийн засгийн бодлогын баримт бичигт тусгуулсан байна. Рио Де Жанейро хотод 1992 онд болсон НҮБ-ын дээд хэмжээний уулзалтаас “Хүрээлэн буй орчин ба хөгжлийн талаар тунхаглал” гаргаж байсан. Рио-гийн бага хурлаас (UNCED) баталсан тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг үндэслэн 1995 онд Монгол Улсын тогтвортой хөгжлийн Үндэсний зөвлөл байгуулж, (Засгийн газрын 2009 оны 82 дугаар тогтоолоор шинэчлэн өөрчилсөн) Монгол Улсын Ерөнхий сайд удирдан ажиллаж байсан байна. Энэ зөвлөлийн ажлын хүрээнд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын 21 зууны тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөр боловсруулж, Засгийн газрын 1998 оны 82 дугаар тогтоолоор хэрэгжүүлж ажиллаж байсан байна.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээнд хэрэгжүүлэх "Ус" үндэсний хөтөлбөрийг 2010 оны 05 сарын 20-ны өдөр УИХ-ын 24 тоот тогтоолоор баталсан. Улмаар УИХ-ын 89 тоот тогтоолоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх

хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдаа холбоо, нийцлийг хангаж, давхардал, зөрчлийг арилгах зорилгоор хүчингүй болгож шийдвэрлэжээ.

Монгол Улсын усны нөөц, ашиглалтын байдал: Монгол орны усны нийт нөөц сүүлийн 40 жилд хийсэн судалгааны дүнгээр 608,000 сая шоо метр ба үүнд 34,600 сая шоо метр гол, мөрөн, 500,000 сая шоо метр нуур, 62,900 сая шоо метр мөнх цас, мөсөн гол, 10,800 сая шоо метр газрын доорх усны нөөц тус тус багтана. Усны нөөцийн тархалт жигд бус, чанар, найрлага нь оршин байгаа газар нутаг, байгалийн бүс, бүслүүр, агуулж байгаа чулуулгийн тогтоц, найрлагаасаа хамаарч ихээхэн өөр өөр байдаг. Гадаргын усны нөөцийн 70 хувь нь Алтай, Хангай, Хэнтийн нуруу, Хөвсгөлийн уулс, Их Хянганы нуруу зэрэг уул нуруудын өндөрлөг хэсэгт буюу монгол орны нийт нутаг дэвсгэрийн 30 орчим хувийг эзлэх талбайд бүрэлдэн бий болдог. Бүрэлдсэн нөөц нь Хойд мөсөн далай, Номхон далай, Төв Азийн гадагш урсгалгүй ай савуудад хуваарилагдах ба тэдгээрт багтах 17 томоохон гол, мөрөн, тэдгээрийн цутгалуудыг тэжээж, ихэнх голууд нийлэн хөрш орнууд руу урсан гардаг онцлогтой байна. Ус ашиглалтын хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд цаашид хот, суурин газрын усан хангамж, ариутгах татуургын хүртээмжийг сайжруулах, мал аж ахуйн болон газар тариалангийн тогтвортой байдлыг хангах, бэлчээр, газар тариалангийн талбайг усжуулах, хөнгөн, хүнс, уул уурхайн болон бусад үйлдвэрлэлийн салбар, сэргээгдэх эрчим хүчний салбаруудын хөгжлийг тодорхойлох үндсэн дэд бүтцийн нэг, хөгжлийн голлох хүчин зүйл болж байна. Тус судалгааг хийх явцад Усны тухай хуулийн төслийг бэлтгэж байна. Хуулийн төсөлд гадаргын болон газрын доорх уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаарыг ус ашиглах эрхийн эрэмбийг тогтоох, газрын доорх цэнгэг усны ордыг уул уурхай болон үйлдвэрийн зориулалтаар ашиглахыг хориглох зэрэг газар доорх ус, түүний хамгаалалт, ашиглалт болон бусад зохицуулалтын талаарх эрх зүйн орчныг бүрдүүлсэн заалтууд тусгагдсан байна. Мөн орхигдсон цооногийг сум, дүүргийн Засаг дарга улсын төсвийн хөрөнгөөр битүүмжлэн буруутай этгээдээс учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна гэж зааж, хариуцлагын хэмжээг тодорхойлсон байна.

Судлаачдын нийтлэг үзэж байгаагаар шинжлэх ухааны хувьд ус бол зөвхөн манай дэлхий дээр л оршдог амьдралд хамгийн их үүрэг гүйцэтгэдэг бодис. Түүний үнэт чанар нь химийн аргаар гарган авч болдоггүй, хүн усгүйгээр амьдарч чадахгүйд байдаг учир хязгаарлагдмал нөөцөд тооцогддог. Ус нь устөрөгч, хүчилтөрөгчийн нэгдэл бөгөөд ердийн нөхцөлд өнгө, үнэргүй. Дэлхий дээрх усны нөөцийг эрдэмтэд 1.5 сая шоо км хэмээн тодорхойлжээ.[1] Гэвч нөөцийн хувьд дэлхий дээр байгаа бүх усны 1 хувь нь цэвэр ус, 97 хувь нь далай тэнгисийн ус, 2 хувь нь хойд өмнөд туйлд буй мөсөнд хуримтлагдсан ус учир түүнийг бохирдуулахаас сэргийлэх нь дэлхий нийтийн амин чухал асуудалд тооцогдож байна. Усны бохирдолт гэдэг нь ерөнхий утгаараа ямар нэгэн органик ба эрдсийн бодис усанд орсноос байгалийн унаган төрхөд нь сөрөг нөлөө илрэх явдал юм. Дэлхий нийтийн хэмжээнд 1992 онд Бразил Улсын Рио Де Жанейро хотод чуулсан “Байгаль орчин ба хөгжил” сэдэвт НҮБ-ын дээд хэмжээний чуулга уулзалтаас “Хөгжлийн хөтөлбөр-21” баримт бичгийг баталснаар тогтвортой хөгжлийн асуудал нь дэлхий нийтийн эрхэм дээд зорилго

[1] lesoceans.pdf (panda.org)

болсон гэж үздэг байна. Энэхүү чуулганаар дэлхийн улс орнуудыг тогтвортой хөгжлийн зорилтоо тодорхойлон, Риогийн тунхаглалыг хэрэгжүүлэхийг уриалсан юм.

Харамсалтай нь өнөөдөр усыг хэт их ашиглан, бохирдуулж байгаагаас усны нөөц хомсдох болсон нь хүн төрөлхтнийг түгшээж байна. Нэн тэргүүнд Үйлдвэрийн технологийн хэрэгцээ болон хэрэглэж байгаа түүхий эдээс хамааран гарч байгаа усны бохирдлын хэмжээ харилцан адилгүй гардаг байна. Энэ төрлийн бохирдол нь химийн органик нэгдэл агуулдаг учир цэвэршүүлэхэд зардал өндөр байна. Мөн олон нийт, орон сууц, үйлдвэр аж ахуйн газарт тоноглогдсон угаагуур, шүршүүр, онгоц, суултуур болон бусад сан техникийн төхөөрөмжүүдээр дамжин гарах бохир ус чухал анхаарлын төвд байна. Аль ч төрлийн бохирдол нь бактери агуулах эрсдэлтэй бөгөөд бактерийн бохирдолд усанд өвчин үүсгэгч 700 гаруй төрлийн вирус, эгэл биетэн, мөөг гэх мэт ордог. Бактериар хордсон усыг ахуйд хэрэглэх боломжгүй. Цаашлаад далай тэнгисийн улс орнуудад цацрагийн бохирдол түгээмэл тохиолддог байна. Цацраг идэвхт бодис усанд маш бага хэмжээгээр байсан ч гэсэн асар хүчтэй бохирдлыг үүсгэдэг байна. Иймд бохирдол үүсгэж байгаа этгээдийн хэрэглээг хязгаарлах, сөрөг нөлөөг бууруулахын тулд төрийн эрх бүхий байгууллагаас стандарт тогтоохоос гадна бохирдлыг үүсгэгч эх үүсвэрээс эд засгийн нөхөр төлбөрийг хураан авах нь дэлхий нийтээр хэрэгжүүлдэг арга болжээ. Бохирдуулагч төлөх зарчим (Polluter Pay Principle)[2]-ын дагуу хүрээлэн буй орчинд учруулсан бохирдлыг багасгах, түүнээс урьдчилан сэргийлэхэд зарцуулах төсвийг бохирдуулагч өөрөө хариуцах ёстой талаар 1974 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын хурлын үеэр дурдагдан улмаар 1992 онд Бразил Улсын Рио Де Жанейро хотод чуулсан “Хүрээлэн байгаа орчин ба хөгжил” сэдэвт НҮБ-ын дээд хэмжээний чуулга уулзалтаар баталсан Хүрээлэн буй орчин ба Хөгжлийн асуудлаарх Риогийн Тунхаглалын 16 дугаар зүйлд зарчмаар тусгагдсан.[3] Зарчмын гол утга нь улсын аливаа эрх баригчид нийтийн ашиг сонирхлыг зохих ёсоор харгалзан, олон улсын худалдааг гажуудуулахгүйгээр бохирдуулагч нь зарчмын хувьд бохирдлын зардлыг хариуцах ёстой гэсэн хандлагыг харгалзан байгаль орчны зардлыг дотооддоо нэвтрүүлэх, эдийн засгийн хэрэгслийг ашиглахыг дэмжихийг хичээх ёстойг тодорхой тусгасан. Тус зарчмын түгээмэл жишээнүүдийн нэг нь гялгар уутны жишээ юм. 2016 оноос хойш Нидерланд дахь жижиглэнгийн худалдаачид гялгар уутыг үнэгүй өгөхийг хориглосон бөгөөд үйлчлүүлэгчид нэгийг нь төлөх эсвэл үйлчлүүлэгч өөрийн цүнхээ авч явах талаар дүрэм тогтоосон байна. Ус бохирдуулсны төлбөрийг бохирдуулагч бодисын хэмжээгээр, бохир усны хэмжээгээр болон бүтээгдэхүүн үйлчилгээнд ногдуулах замаар авдаг. Эдгээрээс хамгийн өргөн хэрэглэгддэг арга нь бохирдуулах бодисын хэмжээнд төлбөр ногдуулах арга юм. Олон улсын практикаас үзэхэд бохирдуулсны төлбөрийг

[2] The 'polluter pays' principle is the commonly accepted practice that those who produce pollution should bear the costs of managing it to prevent damage to human health or the environment.

[3] OECD, Addressing Industrial Air Pollution in Kazakhstan: Reforming Environmental Payments Policy Guidelines, 2019 A/CONF.151/26/Vol.I: Rio Declaration on Environment and Development (un.org) Principle 16. National authorities should endeavour to promote the internalization of environmental costs and the use of economic instruments, taking into account the approach that the polluter should, in principle, bear the cost of pollution, with due regard to the public interest and without distorting international trade and investment.

бохирдуулагч өөрийн гаргаж буй бохирдлоо хянаж, бууруулахад нөлөө үзүүлэхүйц өндөр тогтоогддог байна. Бохирдсон, хаягдал усыг нийтийн эзэмшлийн усан орчин болон газрын доорх усанд нийлүүлж байгаа ариутгах татуургын байгууллагууд, компаниудад стандартаас давсан тохиолдолд торгууль хэлбэрээр нөхөн төлбөр ногдуулдаг. Олон улсын жишгээр бохир усыг шууд болон цэвэрлэж байгальд нийлүүлж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс бохирдуулсны төлбөрийг авдаг байна. Ус бохирдуулсны төлбөр нь ариутгах татуургын системд холбогдсон хэрэглэгчийн төлбөр, хаягдал усны төлбөр гэсэн үндсэн хоёр хэлбэртэй байдаг. Ихэвчлэн хаягдал усан дахь бохирдуулагч бодисын хэмжээнд суурилан тогтоогддог байна. Ариутгах татуургын системд холбогдсон хэрэглэгчдийн төлбөр нь түүний ус хэрэглээний хэмжээгээр тогтоогдох бөгөөд ариутгах татуургын үйлчилгээний тарифт шингэсэн шууд бус төлбөр (татвар) байдаг. Харин хаягдал усны төлбөрийг ус, усан орчинд бохирдуулагч бодис нийлүүлж байгаа этгээдээс авдаг. Бие даасан Ус бохирдуулсны төлбөрийн тухай тусдаа хуультай улс оронд Япон /Усны бохирдлыг хянах тухай хууль-Water Pollution Control Law-1971/ зэрэг цөөн хэдэн улс ордог бол ихэнх улс орнуудад Усны тухай хууль, Усны чанарын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ус хангамж, ариутгах татуургын хуулиудаараа усны бохирдлын асуудлыг зохицуулсан байдаг байна. Япон улс Усны бохирдлыг хянах тухай хуулиараа гол, нуур, далайн боомт, эрэг орчмын газрууд, нийтийн эзэмшлийн сувгийг бохирдлоос хамгаалах зорилгоор үйлдвэр бизнес эрхлэгчдэд төлбөр ногдуулдаг байна. ОХУ, Казахстан зэрэг газарт үйл ажиллагааны явцдаа усанд ямар нэг бодис хийсэн тохиолдолд төлдөг. Айл өрх чөлөөлөгдсөн байдаг. Стандартаас доогуур бол бодисын хэмжээнээс хамаарна, дээш гарвал түүнээс 3-5 дахин их, зөвшөөрөгдөх дээд хязгаараас давбал 3-5 дахин нугалсан нөхөн төлбөр төлдөг байна. ОХУ-д уг төлбөрийн хэмжээг 1992 оноос мөрдүүлж, төлбөрийн зохицуулалтыг нутгийн захиргааны байгууллага (хотын Мэр) тогтоодог. Төлбөр нь бохирдуулагч бодисын төрлөөр буюу суурин болон хөдөлгөөнт эх үүсвэрээс гадаргын болон газрын доорх ус, усан орчинд нийлүүлэгдэж байгаа бохирдуулагч бодисын төлбөрийн хэмжээг 1 тоннд ногдох рублиэр 198 төрлийн бодис тус бүрээр тогтоосон байдаг. Ус бохирдуулсны төлбөрийн тухай бие даасан хууль байдаггүй. "Хүрээлэн буй орчныг хамгаалах тухай" Холбооны хууль /10.01.2002/ "Ус хангамж, ариутгах татуургын тухай" Холбооны хууль /07.12.2011/ болон хаягдал усан дахь бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх хэмжээ, зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоосон, бохирдуулагч бодисын хэмжээг тогтоох, төлбөр тооцох асуудал зэргийг зохицуулсан холбогдох бусад хууль, эрх зүйн баримт бичгүүдээр зохицуулагддаг байна. Түүнчлэн Чех, Хятад, АНУ, Киргиз зэрэг орнуудын ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, тогтоомжуудтай танилцахад Чех улсын усны хуульд ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гаргаж буй хаягдал усны эзлэхүүн болон бохирдолд төлбөр ногдуулдаг байна. Хаягдал усанд агуулагдах ус бохирдуулах бодис тус бүрийн хэмжээг тухайн жилд ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хаяж буй хаягдал усны эзлэхүүнийг ус бохирдуулах бодис тус бүрийн жилийн дундаж агууламжаар үржүүлж тооцдог байна. Хятад улсын байгаль хамгаалах хуульд хаягдал усны стандартаас давсан бохирдолтой хаягдал ус гаргаж буй ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хаягдал усны эзлэхүүн болон стандартаас давсан бохирдуулах бодис тус бүрийн агууламжаас

хамааруулан нөхөн төлбөр тооцохоор заасан байдаг. Хятад улсад үндэсний болон орон нутгийн түвшинд мөрдөгдөх хаягдал усны стандарт өөр өөр байх бөгөөд орон нутгийн түвшинд хаягдал усны стандарт нь үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, үйлчилгээний газрын үйл ажиллагааны төрөл онцлогоос хамааруулан үндэсний стандартад тусгагдаагүй бодисын төрлүүд болон тэдгээрийн зөвшөөрөгдөх дээд агууламжийг илүү хатуу тогтоож өгдөг. АНУ-ын хувьд хүн амын тоо, зонхилж буй үйлдвэрүүд болон тэдгээрийн хүчин чадал, тухайн мужийн байгалийн нөхцөл байдлаас хамааран муж тус бүрд өөр өөр хаягдал усны стандарт мөрдөгддөг байна.

Нидерланд улсад бохирдуулагч нэгжийг тогтоон үл хөдлөх хөрөнгөд ногдуулан авч байна. Герман улсад бохирдлын төлбөр нь бохирдлоос урьдчилан сэргийлэх зориулалттай эсвэл байгаль хамгаалах арга хэмжээнд зориулж төлбөр авдаг /Экосистемийн үйлчилгээний төлбөр/. Франц улсад бохир ус нийлүүлсний төлбөр болон бохир ус цэвэршүүлсний зардлыг багтааж авдаг байна. Бохирдуулагчаас хураасан төлбөрөөр ус цэвэршүүлэх байгууламжуудаас гадна усан орчны чанарын хяналт тавьдаг байгууллагуудыг санхүүжүүлдэг. Түүнчлэн Их британи зэрэг зарим өндөр хөгжилтэй орнуудад хаягдал усны зах зээл хөгжсөн байдаг бөгөөд үйлдвэр бүр жилд тодорхой хэмжээний бохирдол байгальд нийлүүлэх зөвшөөрөл авч тэр хэмжээндээ хүргээгүй эсвэл бууруулах арга хэмжээ авсан тохиолдолд илүү гарсан эрхээ зах зээлд борлуулдаг. Дэлхий нийтийн жишигт хөдөө аж ахуйн салбарт үнэгүй ус хэрэглүүлдэггүй бөгөөд хөдөө аж ахуйн ус хэрэглээ, ус ашиглалтын ихэнх хувийг эзэлж усны хомсдол, хүнсний аюулгүй байдлын тулгамдсан асуудал болж байгаа. Манайд ч хөдөө аж ахуйн хэрэглээ нийт ус ашиглалтын 42%-ийг эзэлж байна. Бохирдуулагч төлөх зарчим (PPP)-ын талаар: Polluter-Pays Principle (PPP) буюу бохирдуулагч төлөх зарчмыг анх 1972 онд ЭЗХАХБаас бохирдлыг хянах зардлыг хуваарилах эдийн засгийн зарчим болгон баталсан байна.[4] 1972, 1974 оны ЭЗХАХБ-ын гаргасан зөвлөмж (1)(2)-ын дагуу энэ зарчим нь бохирдуулагч "бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээний зардлыг хариуцах ёстой" гэсэн утга илэрхийлнэ гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, бохирдуулагч нь байгаль орчныг хамгаалахын тулд хууль ёсны дагуу хийх ёстой арга хэмжээ, тухайлбал бохирдуулагчийн ялгаралтыг эх үүсвэрээс нь бууруулах, бохирдуулагч байгууламжаас гарсан бохир усыг ангилах, зайлуулах, цэвэршүүлэх бусад зардлыг өөрөө хариуцах ёстой гэсэн зарчмыг илэрхийлдэг. Тус зарчим болоод НҮБ-ын дээд хэмжээний чуулга уулзалтаар баталсан Хүрээлэн буй орчин ба Хөгжлийн асуудлаарх Риогийн Тунхаглал нь үндсэндээ тус хуулийг амьдралд үр дүнтэй хэрэгжүүлэх төрийн бодлогыг тодорхойлох гол эх сурвалж баримт бичиг гэж судлаачийн хувьд дүгнэлээ. Хууль тогтоомж үр дүнтэй, урт хугацаандаа эдийн засгийн үр өгөөжтэй хэрэгжих үндэслэл нь манай улсын өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ, усны бохирдлын байдалд хийсэн дүгнэлтийг тодорхой хийх, үүний үндсэн дээр олон улсын гэрээ конвенцод тусгагдсан дэлхий нийтээр тохирсон аргыг бодитой хэрэглэх нь оновчтой гэж үзэж байна. Иймээс усны бохирдол, төлбөрийн талаар гаргасан дотоод мэдээлэл, судалгаа, тайлан байх нөхцөлд судалгааны ажилд тустай байгааг дурдаж байна.

[4] https://www.oecd.org/en/publications/oecd-archives/oecd-official-documents.html?orderBy=mostRelevant&page=0

ХОЁР. АСУУДЛЫГ ҮҮСГЭЖ БУЙ УЧИР ШАЛТГААН

Усны нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлттэй холбоотой эрх зүйн зохицуулалт нь нийгэм, эдийн засаг, байгаль орчны хөгжлийн үндсэн нөхцөл болдог. Гэвч өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа усны тухай хууль болон түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн явцад тодорхой хүндрэл, хийдэл, давхардал үүсэж байгаа нь салбарын бодлого, удирдлага, хяналт, зохицуулалтад сөргөөр нөлөөлж байна.

Нэгдүгээрт, усны нөөцийн нэгдсэн менежментийн тогтолцоо бодит хэрэгжилтийн түвшинд хангалтгүй байна. Ус ашиглалт, хамгаалалт, бохирдлын хяналт, нөхөн сэргээлттэй холбоотой чиг үүрэг төрийн байгууллагуудын хооронд давхцах, уялдаа сул байх нөхцөл байдал үүссэн нь шийдвэр гаргалт, хяналт-шинжилгээ, мэдээллийн нэгдсэн тогтолцоонд хүндрэл бий болгож байна.

Хоёрдугаарт, усны нөөцийн хомсдол, бохирдол нэмэгдэж байгаа хэдий ч хууль тогтоомжид урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, тогтвортой ашиглалтыг хангах зохицуулалт хангалтгүй байна. Ялангуяа уул уурхай, үйлдвэрлэл, хотжилт, хүн амын төвлөрөл нэмэгдэхийн хэрээр гадаргын болон газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөлөл өсөж байгаа боловч хамгаалалтын механизм, хариуцлагын тогтолцоо хангалттай үр нөлөөтэй хэрэгжихгүй байна.

Гуравдугаарт, ус ашиглагч иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, хариуцлагын зохицуулалт тодорхой бус, хэрэгжилтийн хяналт сул байгаа нь усны зохисгүй хэрэглээ, хэт ашиглалт, бохирдол үүсэх нөхцөлийг бий болгож байна. Мөн ус ашигласны төлбөр, эдийн засгийн хөшүүрэг, усны үнэлгээний тогтолцоо нь бодит хэрэглээ, нөөцийн үнэ цэнтэй бүрэн нийцэхгүй байгаа нь ус хамгаалах эдийн засгийн сонирхлыг бууруулж байна.

Дөрөвдүгээрт, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, усны нөөцийн тархалтын тэнцвэргүй байдал нэмэгдэж байгаа өнөөгийн нөхцөлд усны салбарын эрх зүйн зохицуулалтыг олон улсын чиг хандлага, тогтвортой хөгжлийн зорилттой нийцүүлэн шинэчлэх шаардлага үүсээд байна.

Түүнчлэн усны асуудалтай холбоотой мэдээллийн сан, судалгаа, мониторингийн тогтолцоо хангалтгүй, салбар хоорондын мэдээлэл солилцоо сул байгаа нь нотолгоонд суурилсан бодлого боловсруулах, хэрэгжилтийг үнэлэх ажиллагаанд хүндрэл учруулж байна.

Иймд усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, усны аюулгүй байдлыг хангах, төрийн байгууллагуудын чиг үүргийн уялдааг сайжруулах, олон улсын жишигт нийцсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Усны тухай хуулийг шинэчлэн боловсронгуй болгох шаардлага үүсэж байна.

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Энэхүү хуулийн төслийн зорилго нь усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, усны аюулгүй байдлыг хангахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, усны салбарын удирдлага, зохион байгуулалт, хяналт, хариуцлагын тогтолцоог олон улсын чиг хандлага, тогтвортой хөгжлийн зорилттой нийцүүлэн шинэчлэхэд оршино.

Түүнчлэн усны нөөцийн нэгдсэн менежментийг бэхжүүлэх, төрийн байгууллагуудын чиг үүргийн уялдаа холбоог сайжруулах, ус ашиглалттай холбоотой зөвшөөрөл, төлбөр, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, ус бохирдуулах, хомсдуулах эрсдэлийг бууруулах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэнэ.

Мөн усны нөөцийн хамгаалалт, ашиглалтын талаарх мэдээллийн нэгдсэн сан, мониторингийн тогтолцоог сайжруулах, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, усны үнэ цэнэ, үр ашигтай хэрэглээг дэмжих эдийн засгийн болон эрх зүйн хөшүүргийг бий болгох зорилготой.

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа
1. Одоо мөрдөгдөж байгаа эрх зүйн зохицуулалтын хүрээнд захиргааны болон бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Усны нөөцийн хамгаалалт, ашиглалттай холбоотой тодорхой асуудлыг салбарын бодлого, хөтөлбөр, захиргааны арга хэмжээгээр хэсэгчлэн зохицуулах боломжтой. Гэвч усны нөөцийн нэгдсэн менежмент, байгууллагуудын чиг үүргийн уялдаа, хяналт, хариуцлагын тогтолцооны давхардал, хийдлийг бүрэн арилгах боломж хязгаарлагдмал хэвээр байна. Мөн усны бохирдол, хомсдол, зохисгүй ашиглалтыг бууруулах эрх зүйн үр нөлөө хангалтгүй байна.	Улсын төсөвт шууд нэмэлт зардал харьцангуй бага гарах боловч урт хугацаанд усны нөөцийн доройтол, бохирдол, усны үр ашиггүй хэрэглээ, байгаль орчны эрсдэл нэмэгдэх сөрөг үр дагавар үргэлжилнэ. Мөн салбар хоорондын зохицуулалтын сул байдал нь эдийн засаг, нийгмийн нэмэлт зардал үүсгэх эрсдэлтэй.
2. Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж батлуулах	Усны нөөцийн хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээлттэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг цогцоор нь боловсронгуй болгож, усны нэгдсэн менежментийн	Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд тодорхой хэмжээний зохион байгуулалт, хяналт, мэдээллийн системийн зардал шаардагдана. Гэвч

	тогтолцоог бэхжүүлэх боломж бүрдэнэ. Төрийн байгууллагуудын чиг үүргийн уялдаа сайжирч, хяналт, зөвшөөрөл, хариуцлагын механизм тодорхой болно. Мөн усны нөөцийн тогтвортой ашиглалт, усны аюулгүй байдал, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүргийг олон улсын чиг хандлагад нийцүүлэн зохицуулах нөхцөл бүрдэнэ.	дунд болон урт хугацаанд усны нөөцийн хамгаалалт сайжирч, ус ашиглалтын үр ашиг нэмэгдэх, байгаль орчны доройтол буурах, тогтвортой хөгжлийг дэмжих эдийн засаг, нийгмийн үр өгөөж бий болно.

Хуулийн төслийг баталснаар усны салбарын эрх зүйн орчин боловсронгуй болж, усны нөөцийг урт хугацаанд тогтвортой хамгаалах, хүн ам, эдийн засаг, экосистемийн усны хэрэгцээг тэнцвэртэй хангах, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эрсдэлийг бууруулах нөхцөл бүрдэнэ.

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-д заасны дагуу усны салбарт үүсээд байгаа асуудлыг зохицуулах боломжит хувилбаруудыг тодорхойлон, тэдгээрийн еерэг болон сөрөг талыг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛЖ БОЛОХ ХУВИЛБАРУУДЫН ЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛ

№	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхгүй байх	Өнөөгийн тулгамдаж буй бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгодоо хүрэх боломжгүй	Нэмэлт зардал гарахгүй боловч тулгамдсан асуудал хэвээр үргэлжилнэ	Үр дүн сөрөг
2	Хоолой мэдээллийн хэрэгслээр урьдчилан сурталчилгаа хийх	Өнөөгийн тулгамдаж буй бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд асуудлыг шийдвэрлэх боломжгүй	Зардал хэмнэнэ. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгаж, сөрөг үр дагаврыг	Тодорхой үр дүнд хүрэхгүй

			бууруулах чадваргүй	
3	Эх эзэмшигчийн эрхийн эсэхийн хэрэглэгчийн ашиглалт торгох зохицуулалт хийх	Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах асуудал нь төрийн зохицуулалттайгаар шийдвэрлэгдэж, эрхийн үр дүнд дээрх хэрэгцээ нийтийн харилцаа тул эх эзэмшигч эрхийн хэрэглээг ашиглан торгох зохицуулалт хийх замаар шийдвэрлэх боломжгүй	Зардал хэмнэгдэнэ. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлөх сөрөг үр дагаврыг бууруулах чадваргүй	Үр дүн сөрөг
4	Торгосон санхүүгийн интеграци хийх	Тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд тодорхой санхүүжилт шаардлагатай ч хуульд тогтоосон зохицуулалт хэрэглэх боломжгүй	Зардал хэмнэгдэнэ. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлөх сөрөг үр дагаврыг бууруулах чадваргүй	Тодорхой үр дүнд хүрэхгүй
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Төрийн тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжийг судлах шаардлагатай	Байгууллагын эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх боломжтой	Үр дүнтэй
6	Зөвшөөрлийн шийдвэр гаргах	Хуулийн үйлчлэл хүрээнд тодорхой асуудлыг зөвшөөрлөөр шийдвэрлэх боломжийг судалсан боловч бүрэн шийдвэрлэх боломжгүй	Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг цэгцээр нь арилгаж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулах чадваргүй	Тодорхой үр дүнд хүрэхгүй
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Усны тухай хуульд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой	Зардал гарах боловч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг бүрэн шийдвэрлэхэд чухал	Үр дүнтэй

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар иргэд олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй байна.

Иймд асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжих механизмыг бүрдүүлэх зорилтод хүрэхийн тулд Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зохицуулалтын хувилбарын үр нөлөөг эрх зүй, нийгэм, эдийн засаг, байгаль орчин, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийн хүрээнд тандан судлав.

5.1. Эрх зүйн үр нөлөө

Хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаар усны нөөцийн хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээлттэй холбоотой эрх зүйн зохицуулалт илүү тодорхой, уялдаатай болно. Усны салбарт үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа төрийн байгууллагуудын чиг үүрэг, бүрэн эрх, хариуцлагын зааг ялгаа тодорхой болж, хуулийн хийдэл, давхардлыг арилгах нөхцөл бүрдэнэ.

Түүнчлэн ус ашиглагч иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулснаар усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах эрх зүйн орчин боловсронгуй болно.

5.2. Нийгмийн үр нөлөө

Хуулийн төсөл хэрэгжсэнээр хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл сайжирч, цэвэр усны хүртээмж, усны аюулгүй байдалтай холбоотой эрх ашиг хамгаалагдана. Усны бохирдол, хомсдолоос үүдэлтэй сөрөг нөлөөллийг бууруулах нөхцөл бүрдэж, иргэдийн ус ашиглах соёл, хариуцлага дээшлэх эерэг үр нөлөөтэй. Мөн усны нөөцтэй холбоотой мэдээллийн ил тод байдал, олон нийтийн оролцоо нэмэгдэж, ус хамгаалах үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгжийн оролцоог дэмжих ач холбогдолтой.

5.3. Эдийн засгийн үр нөлөө

Усны нөөцийг үр ашигтай ашиглах, хамгаалах эрх зүйн орчин бүрдсэнээр ус ашиглалтын үр ашиг нэмэгдэж, усны хомсдол, бохирдлоос шалтгаалах эдийн засгийн эрсдэл буурна. Ус ашигласны төлбөр, эдийн засгийн зохицуулалт боловсронгуй болсноор усны үнэ цэнийг нэмэгдүүлэх, хариуцлагатай хэрэглээг дэмжих боломж бүрдэнэ.

Хэдийгээр хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд тодорхой хэмжээний зардал шаардагдах боловч дунд болон урт хугацаанд усны нөөцийн доройтол буурч, байгаль орчин, үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, хүн амын ус хангамжтай холбоотой тогтвортой хөгжлийн үр өгөөж бий болно.

5.4. Байгаль орчны үр нөлөө

Хуулийн төсөл нь усны нөөцийг хамгаалах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах эрх зүйн үндсийг бэхжүүлнэ. Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хамгаалалт сайжирч, усны эх үүсвэрийн доройтол, хомсдол, бохирдлыг бууруулахад эерэг нөлөө үзүүлнэ.

Мөн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой усны эрсдэлийг бууруулах, усны нөөцийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх юм.

5.5. Төрийн байгууллагын үйл ажиллагаанд үзүүлэх үр нөлөө

Төрийн байгууллагуудын чиг үүргийн уялдаа, мэдээлэл солилцоо, хяналт-шинжилгээний тогтолцоо сайжирч, усны салбарын бодлого, төлөвлөлт илүү үр нөлөөтэй хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Мөн усны мэдээллийн нэгдсэн сан, мониторингийн тогтолцоог боловсронгуй болгосноор нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжинэ.

Иймд Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зохицуулалтын хувилбар нь эрх зүй, нийгэм, эдийн засаг, байгаль орчин болон төрийн удирдлагын хувьд эерэг үр нөлөөтэй гэж үзэв.

Хүний эрх, эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3-аас үзнэ үү.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Монгол Улс нь Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Рамсарын Конвенцод 1998 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр нэгдэн орсон. Өнөөдрийн байдлаар энэ конвенцын хүрээнд манай орны нийт 13 нуур хамарч байна. Конвенцод нэгдэн орсон улс орнууд өөрийн орны ус, намгархаг газруудыг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор төсөл боловсруулах, санхүүжилт олох, түүнчлэн шаардлагатай тохиолдолд Рамсарын Зөвлөх Багийн тусламжтайгаар Конвенцоор хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд тулгарч буй бэрхшээл, цаашид авах арга хэмжээг тодорхойлуулж, цаашлаад санхүүжилт авах боломжтой юм. Манай улсын тайлангаас харахад дээр дурдсан тусламж болон хамтын ажиллагаанд оролцоогүй байна. Ийнхүү хүлээсэн үүргээ бүрэн гүйцэд гүйцэтгэж чадахгүй байгаагийн нэг шалтгаан бол Рамсарын Конвенцыг хэрэгжүүлэх, үндэсний хэмжээнд хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд Усны асуудал эрхэлсэн Засгийн газрын эрх бүхий байгууллагын оролцоо дутагдаж байгаатай холбоотой болов уу. Иймд эрх бүхий байгууллагын бүрэн эрхэд олон улсын гэрээ, конвенцын хүрээнд Монгол улсын хүлээсэн үүргийг биелүүлэх ажлыг зохион байгуулах эрхийг олгох тухай хуульчлах зайлшгүй шаардлагатай юм.

Усны тухай хуулиар олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол улсын Засгийн газар олон улсын сав газрын усны нөөцийг зохистой ашиглах, бохирдох, хомсдохоос хамгаалах, мэдээлэл солилцох, хамтран судалгаа хийх, чанарын хяналт хийх зэрэг тал дээр хамтран ажиллахаар ОХУ-ын Засгийн газартай 1995 оны 2 дугаар сарын 11-ний өдөр, БНХАУ-ын Засгийн газартай 1994 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр тус тус хилийн усны гэрээ хэлэлцээр байгуулсан. Хөрш 2 оронтой байгуулсан эдгээр хилийн усны гэрээ хэлэлцээрт усны нөөцийн нэгдсэн менежментийн олон улсын сав

газарт баримтлах зарчмуудыг тусгаагүй байна. Харин Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2010 оны 10 дугаар сарын 21-ний өдөр соёрхон батлахдаа хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд “Талууд хилийн ус, түүний эргийн экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах, хөрсний идэгдэл, хүний буруутай үйл ажиллагаанаас үүдсэн бохирдол болон бусад тааламжгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авна. Талуудын эрх бүхий байгууллага хилийн усны урсгалын хэмжээ, усны түвшин, усны чанар, мөстөлтийн байдал зэрэг мэдээллийг солилцож, шаардлагатай үед ус зүйн болон усны чанарын хамтарсан хэмжилт хийж, үер болон цөн түрэх зэрэг аюулаас урьдчилан сэргийлнэ” гэж заасан байна.

Хил дамнасан голыг бохирдлоос сэргийлэх, хянах зорилгоор НҮБ-ын Европын Эдийн засгийн хорооны 56 гишүүн орнууд Хил дамнасан гол горхи, нуурын ашиглалт, хамгаалалтын конвенцыг баталж, уг конвенцын хүрээнд хамтын ажиллагааныхаа хамрах хүрээг тодорхойлсон. Конвенц гурван зарчим дээр тогтоно. Нэгд, урьдчилан сануулах зарчим (бодис, түүний хил дамнасан нөлөөллийн хооронд баталгаажсан шалтгаант холбоо байхгүй ч гэсэн аюултай хорт бодис хаяхаас зайлсхийх ёстой); Хоёрт, Бохирдуулагч төлөх зарчим (бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах, бууруулах арга хэмжээний зардал 51 бохирдуулагчаас гарах ёстой); Гуравт, Ирээдүй хойч үеийнхээ хэрэгцээг хангах боломжийг хөндөлгүйгээр өнөө үеийнхээ хэрэгцээг хангаж байхаар усны нөөц зохицуулагдах ёстой гэсэн зарчим болно. Мөн тус конвенцод зааснаар төр нь хилийн усны талаар (1) байгаль орчинд ээлтэй арга барилаар зүй зохистой менежмент явуулах; (2) ухаалаг, шударга замаар ашиглах; (3) экосистемийн хамгаалал, нөхөн сэргээлтийн ажлуудыг хийх үүрэг хүлээнэ. Хил дамнасан усны сав газарт хамаарагддаг улс орнууд хил дамнасан усаа хамгаалахад хамтарсан бодлого, стратеги, хөтөлбөрөөрөө чиглүүлж хамтран ажиллахад тус конвенц дэмжлэг үзүүлдэг бөгөөд тус конвенцын гишүүн биш улсууд ч конвенцын зарчим, талуудын хүлээх үүргийн талаарх зохицуулалтыг хилийн усны гэрээ, хэлэлцээртээ чиг хандлага болгон тусгадаг байна. Олон улсын хэмжээнд хилийн усны ашиглалттай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор 1997 онд НҮБ-аас “Тээврийн бус аргаар олон улсын хилийн ус ашиглах тухай хууль” буюу НҮБ-ын Конвенцыг боловсруулсан . Манай улсын хувьд уг Конвенцод санал өгөхөөс татгалзсан орны тоонд багтаж байгаа.

Оросын Холбооны Улс

ОХУ-ын Засгийн газрын 2004 оны “Холбооны агентлагийн дүрэм батлах тухай” 282 дугаар тогтоол, 2006 оны Усны тухай Холбооны кодекс буюу иж бүрэн хуулиар усны нөөцийн ашиглалт, удирдлагын асуудлыг зохицуулж байна. ОХУ-ын хувьд анх 1995 онд Усны тухай хууль баталсан бөгөөд уг хуулиар усны харилцааг бүрэн зохицуулж чадахгүй байснаас гадна, усны асуудлаар Үндсэн хуулийн, Иргэний хуулийн зохих зохицуулалт болон усны асуудлаар олон улсын хууль тогтоомжийн зарчмын зохицуулалтыг хангалттай тусгаагүй байсан. Мөн ус, суваг ашиглалтын практик, бусад хууль тогтоомжтой уялдаагүй байдал нь уг хуулийг бүхэлд нь шинэчлэх шаардлагыг үүсгэн 2006 онд Усны тухай шинэ кодекс буюу хуулийг

шинэчилсэн найруулгаар баталсан байна. 2006 онд энэхүү Усны тухай хуулийг мөрдөж эхлүүлэх холбооны хуулийн дагуу Иргэний хууль, Захиргааны зөрчлийн тухай, Газрын тухай, Хот төлөвлөлт, байгуулалтын тухай зэрэг холбооны хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Ийнхүү дээрх Усны тухай хууль нь ус ашиглах, хамгаалах, сэргээх асуудалтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг үндсээр өөрчилж зохих шинэчлэлийг хийсэн байна. Тухайлбал, ус ашиглах тусгай зөвшөөрлийн асуудлыг хялбаршуулан ус ашиглалтын гэрээний ач холбогдлыг нэмэгдүүлж тухайн асуудлаар төрийн захиргааны оролцоог багасгасан. Ус ашиглах гэрээг иргэний эрх зүйн гэрээний нэгэн төрөлд хамааруулан авч үзсэн. Мөн энэхүү хуулиар ус ашиглалтын гэрээгээр үүсэх эрх, үүргийг төрийн болон орон нутгийн байгууллагын зөвшөөрлөөр гуравдагч этгээдэд шилжүүлэх асуудлыг тусган өгсөн. Өмнөх усны татварын бодлогыг усны төлбөрөөр өөрчилж Усны тухай хуулийн дагуу байгуулагдсан ус ашиглалтын гэрээнд үндэслэн усны төлбөр төлөх асуудлыг зохицуулсан. Энэ хуулийн онцлог бол ус ашиглалтын асуудлын хүрээнд захиргааны эрх зүйн харилцааг багасгаж иргэний эрх зүйн харилцаанд 52 шилжсэн, усны асуудлаар удирдлагыг Холбооны субъектүүдэд шилжүүлж өгсөн, усны татварыг ус ашиглалтын төлбөрөөр аажим өөрчилсөн, хиймэл усан байгууламжийг өмчлөх институтийг нэвтрүүлсэн. Түүнчлэн Иргэний хуулийн холбогдох зохицуулалтыг хэрэглэх боломжийг олгосноор усны харилцаатай холбоотой зарим асуудлыг шийдвэрлэхэд захиргааны байгууллагын дур зоргоор хандаж байсан хандлагыг өөрчилсөн. Тухайлбал, захиргааны байгууллагын нэг талын санаачилгаар өөрийн эрх мэдлээр хувь болон хуулийн этгээдийн ус ашиглах эрхийг дуусгавар болгох, хязгаарлах боломжтой байсныг өөрчилжээ. Үзэл баримтлалын хувьд Усны тухай хууль нь усны хууль тогтоомжийн үндсэн зарчмыг тусгаж өгсөн. Хуулиар тогтоосон энэхүү зарчимд цаашдын хууль тогтоомжийн зохицуулалт нийцэж байх ёстой бөгөөд тодорхой хэмжээгээр бодлогын суурь, хөгжлийн баримжаа болно. Эдгээр зарчмаас дурдвал:

- ус хүний аж амьдралын үндэс болох үнэ цэнтэй байх;
- ус ашиглалтаас хамгаалалт нь тэргүүн ач холбогдолтой байх (ашиглалт нь хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөхгүй байх);
- холбооны хуулиар ашиглалтыг хязгаарласан, хориглосон онцгой хамгаалалт бүхий усны объектыг хадгалан хамгаалах;
- усан объектыг зориулалтын дагуу ашиглах;
- бусад зорилгоос ундны болон ахуйн хангамжийн зорилгод тэргүүн ээлжид ач холбогдол өгч эрэмбэ тогтоох;
- хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд иргэн, хуулийн этгээдэд ус ашиглахад тэгш боломж, хүртээмжтэй байх;
- усны аж ахуйн тогтолцоог бүрдүүлж буй усны объектын болон гидротехникийн байгууламжийн харилцан хамаарлыг үндэслэх;
- усан объектыг иж бүрэн ашиглах боломжийг хангах (нэг, эсхүл хэд хэдэн этгээдэд ашиглуулах);
- ус ашиглалт нь төлбөртэй байх;
- усан объектын хамгаалалт эдийн засгийн хөшүүрэгтэй байх (ус ашиглалтын төлбөрийг тогтооход усны сав газрын хамгаалалтын үйл ажиллагааны зардлыг тооцож байх.

Усны харилцааг зохицуулахад баримтлах зарчим:

- усны объектын сав газрын зааг хязгаарыг тогтоох
- усны объектын статус, горим, дэглэмийн онцлогийг харгалзах;
- физик газарзүй, морфометр болон бусад онцлогийг харгалзах.

ОХУ-ын Усны тухай хуулийн өөр нэгэн онцлог нь усан объект гэдэгт уст гадаргууг ойлгохоос гадна эргийн шугамын газрын хэсгийг багтаан ойлгохоор заасан байдаг. Усны тухай хууль нь бусад хууль тогтоомж уруу эшилсэн зохицуулалт цөөнгүй агуулдаг. Энэхүү Усны тухай хуулиас гадна усны асуудлаарх харилцааг зохицуулсан бусад Холбооны улсын хууль, түүнд нийцүүлэн гаргасан Холбооны улсын бусад субъектийн хууль тогтоомж, ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг зэргээр зохицуулдаг бөгөөд тус Усны тухай хууль нь ус ашиглах, хамгаалахтай холбоотой харилцаанд (усны харилцаанд) бусад эрх зүйн актаас давуу хүчин чадалтай байна. Тухайлбал, ОХУ-ын Засгийн газрын 883 тоот тушаалаар (2006 оны 12 дугаар сарын 30-ны өдөр) “Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах нэгдсэн схемийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, нэмэлт өөрчлөлт 53 оруулах журам”-ыг баталсан. Уг журамд, схемийг боловсруулахад оролцох төрийн байгууллагуудыг тодорхойлсноос гадна, түүнийг боловсруулахад тавигдах шаардлагуудыг нарийвчлан тодорхойлсон байна. Мөн, уг баримт бичгийн төслийг хэнд хүргүүлэх, хэрхэн санал өгөх, санал ирүүлэх хугацаа болон түүнийг батлах эрх бүхий байгууллага хүлээн авснаас хойш хэд хоногийн хугацаанд батлах зэрэг зохицуулалтыг тусгажээ. Үүнээс үзэхэд усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний салбар хоорондын уялдааг гаргахын тулд хэн, хэрхэн, юуг тусгаж боловсруулах талаар эрх зүйн зохицуулалт хийх нь зүйтэй болох нь харагдаж байна Усны нөөцийн менежментийн тогтолцоо.

ОХУ-ын Усны тухай хуулийн дагуу Усны нөөцийн ашиглалт, хамгаалалтын төрийн удирдлагын үндсэн нэгж нь сав газар болон гидрографийн нэгж байна. Холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын орон нутгийн байгууллага нь сав газрын хязгаарын болон гидрографийн нэгжийн нутаг дэвсгэр дээр ус ашиглах болон газар ашиглах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих эрхийг хэрэгжүүлдэг. Усны нөөцийн зохистой ашиглалт болон хамгаалалт, усан объектыг сэргээх үйл ажиллагаа, усны бохирдол, ширгэн устахаас сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд төрийн удирдлагын чиг үүргийг Усны нөөцийн Холбооны агентлаг (Росводресурсы), Хэвлий газар ашиглалтын Холбооны агентлаг (Роснедр), Байгалын нөөц ашиглалтын мэргэжлийн хяналтын Холбооны алба(Росприроднадзор), Экологи, технологи болон цөмийн хяналтын Холбооны алба (Ростехнадзор), Хүрээлэн буй орчны гидрометеорологи болон мониторингийн Холбооны алба (Росгидромет) зэрэг хэрэгжүүлнэ.

ОХУ-ын Байгалын нөөц болон экологийн яам (Минприроды России) нь ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2008 оны 724 дүгээр зарлигийн дагуу дээр дурдсан Холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага болон 3 алба, 2 агентлагийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж, зохицуулах үүрэгтэй ажиллахаар тусгасан байна. Энэ яамны үндсэн зохион байгуулалтын үйл ажиллагааг Холбооны Засгийн газрын 2008 оны ОХУ-ын Байгалийн нөөц болон экологийн яамны тухай 404 дүгээр тогтоолоор зохицуулагддаг байна. Энэхүү тогтоолын дагуу яам нь байгалийн баялаг, тэр дундаа тусгай хамгаалалттай газар нутагт буй газрын хэвлий, усны объект, ой, ан

амьтан (агнах зөвшөөрөгдсөн ан амьтнаас бусад) болон тэдгээрийн амьдрах орчныг судлах, ашиглах, сэргээх болон хамгаалах; усан байгууламж, иж бүрэн ашиглагдах усан аж ахуйн тогтолцоо болон гидротехникийн байгууламж зэргийг ашиглах, аюулгүйн байдлыг хангах; гидрометеорологи, хүрээлэн буй орчны мониторинг зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна хүрээлэн орчныг хамгаалах салбарын хүрээнд төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага бөгөөд байгууллага.

Тус яам нь өөрийн чиг үүргээ Холбооны бусад гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, Холбооны бусад субъектийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, өөрөө удирдах ёсны байгууллага, иргэний нийгэм болон бусад холбогдох байгууллагын үйл ажиллагаатай уялдуулж явуулна. Яам нь Засгийн газар өөрийн болон харьяа байгууллагын эрхэлсэн асуудлаар хуулийн төсөл, Ерөнхийлөгчийн болон Засгийн газрын эрх зүйн актын төсөл болон жил тутмын үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөөллийг боловсруулж оруулдаг. Харин гидротехникийн байгууламжийн аюулгүй ажиллагааны төрийн хяналтыг хэрэгжүүлэх албан тушаалын жагсаалт; гидротехникийн байгууламжийн аюулгүй ажиллагааны мэдүүлгийн маягт, 54 гидротехникийн байгууламжийн аюулгүй ажиллагааны асуудлаар улсын шинжээчийн комисс байгуулах болон үйл ажиллагаа явуулах журам; гидротехникийн байгууламжийн улсын бүртгэл явуулах журам, усан сан бүхий газрын экосистемд нөлөөлөх зохистой хэмжээний норматив болон зохистой хэмжээг тогтоох аргачлал, Байгаль болон усан санд нөлөөлөх хортой бодсын жагсаалт, харьяа байгууллагын мөрдөх эрх зүйн акт зэргийн бие даан шийдвэрлэж өөрийн эрх хэмжээний хүрээнд эрх зүйн актыг гаргадаг байна.

Бүгд Найрамдах Казакстан Улс

Бүгд Найрамдах Казакстан Улс нь Усны тухай хуулиа 2003 оны 7 дугаар сарын 9-ний өдөр баталсан. Усны тухай хуулиараа усны хууль тогтоомжийн гол зорилго, зорилт, зарчмуудыг тодорхойлсон бөгөөд усны нөөцөд хяналт, шинжилгээ хийж, усанд үзүүлэх хор уршиг, усны нөөцийн хомсдол, бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон эдийн засгийн хөшүүрэг зэргийг хуульчлан хэрэгжүүлж байна. Бүгд Найрамдах Казакстан Улсын Үндсэн хууль, Усны тухай хууль Газрын хэвлий болон газрын хэвлий ашиглах тухай хууль, Байгаль орчны хууль зэрэг хуулиуд, Засгийн газрын тогтоол бусад хууль эрх зүйн актуудад усны нөөцийг хамгаалах, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулжээ. “Газрын доорх усыг хамгаалах тухай” журмыг 1984 онд баталсан. Энэ журамд газрын доорх усыг ашиглах, газар зохион байгуулалт, ариун цэврийн байгууламж барих, газрын 24 Дэлгэрэнгүй схемийг хавсралт 2-оос /орос хэл дээр/ Сав газрын усан аж ахуйн удирдлагын бүс нутгийн салбар Харьяа байгууллага Сав газрын усан аж ахуйн удирдлага Усны нөөцийн Холбооны агентлаг ОХУ-ын Байгалийн нөөц болон экологийн яам 55 доорх усыг бүртгэх, газрын доорх усны хамгаалалтыг хянах зэрэг чухал заалтуудыг тусгасан байдаг. Усны тухай хуульд газрын доорх усанд хамаарах объектуудыг тодорхой тусгасан. Газрын доорх усны объектод:

- Уст давхарга, давхаргын болон чулуулгийн цогцолбор
- Гүний усны сав газар

• Газрын доорх усны орд

• Газрын доорх ус хуурай газар байгалийн аясаар гарах ус /булаг/ зэргийг багтаан ойлгохоор хуульчилжээ. Усны тухай хуулийн 120 дугаар зүйлд “Газрын доорх усны нөөцийг хамгаалах”, 115 дугаар зүйлд “Усны нөөцийг хомсдохоос хамгаалах” талаар тусгагдсан. Үүнд, усны нөөцийг хомсдохоос хамгаалахын тулд ус ашиглагч иргэн, хуулийн этгээд нь дараах зүйлүүдийг хийх шаардлагатай байхаар заажээ:

1) Усны ашиглах боломжит нөөцөөс хэтрүүлэн ашиглахгүй байх;

2) Усны хамгаалалтын бүс, усан сангийн хагалбар зурваст мал угаах, ариутгах, барилга байгууламж барих, усны нөөцийг хомсдуулах бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэхгүй байх;

3) Усны хамгаалалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

4) Усны нөөцийг хомсдохоос хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэн, хуулийн этгээд нь байгаль орчныг хамгаалах чиглэлийн эрх бүхий улсын байгууллага ба газрын хэвлий судлах эрх бүхий байгууллагатай урьдчилан зөвшилцөж, зөвшөөрөл авсан байна. Казакстан улсын “Газрын хэвлий болон газрын хэвлий ашиглах тухай” хуульд 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдөр нэмэлт, өөрчлөлт орсон. Энэ хуулийн 12 дугаар зүйлд “Ашигт малтмал болон түүний ангилал”-ыг тодорхойлсон байх ба газрын доорх усыг энэ ангилалд хамруулсан. Газрын хэвлийн геологийн судалгаа хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 3 жилийн хугацаанд газрын хэвлийд геологи, геофизикийн судалгаа хийхээс гадна газрын доорх усны эрэл хайгуул хийх эрхтэй байна. Казакстан улсын Байгаль орчны хуульд 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдөр нэмэлт, өөрчлөлт орсон. Энэ хуулийн 34 дүгээр бүлгийн 224 дүгээр зүйлийн 1 дүгээр хэсэгт газрын доорх ус ашиглуулах байгаль орчны шаардлагуудыг тусгасан байна. Энэ бүлэг 2017 оны 21 дугаар сарын 27-ны өдрийн нэмэлтээр хуульд орсон. Казахстан улсын Усны асуудал эрхлэх хороо нь сав газрын зарчмаар усны нөөцийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Нийт 8 сав газрын усны аж ахуйн удирдлагын газрыг (СГУААУГ) байгуулан ажиллуулж байгаа. СГУААУГ-ын гол зорилго нь усны нөөцийн ашиглалтыг удирдах, ус хуримтлуулах, түгээх төлөвлөгөө, тусгай зорилгоор ус ашиглах зөвшөөрөл олгох, ус ашиглалтын улсын бүртгэл хөтлөх, гидротехникийн байгууламж болон усан сангийн аюулгүй байдалд хяналт тавих юм. Улсын чанартай томоохон усны объектын ашиглалтыг “Бартогайскийн усан сан болон Алматагийн их суваг” Төрийн өмчийн үйлдвэрийн газар, “ИртышКараганда” каналын ашиглалтын асуудлаарх Төрийн өмчийн үйлдвэрийн газар хэрэгжүүлдэг.

Гидроузел, үндсэн ус хуримтлуулах хаалт, магистрал шугам, усны сан, насосын станц, усны сүлжээ шугам хоолойн техникийн ашиглалт усны аж ахуйн Улсын чанартай төрийн өмчит үйлдвэрийн газрын бүрэн эрхэд багтдаг. Усны нөөцийн асуудлаар Мужийн хэмжээний хороодоос гадна 14 Төрийн өмчийн үйлдвэрийн “Усны аж ахуй” газар байгуулан ажиллаж байна. Эдгээр усны аж ахуйг эрхлэхээс гадна усны аж ахуйн захиргаа-нутаг дэвсгэрийн зарчмын дагуу хэрэгжүүлнэ. Район болон район дундын усны аж ахуйн тогтолцоо нь удирдлагын хувьд мужийн Төрийн өмчийн үйлдвэрийн газарт хамаарах бөгөөд үйл ажиллагаа нь аж ахуйн тооцооны зарчим дээр үндэслэгддэг. Усны аж ахуйн тогтолцооны удирдах газрын Хөдөө аж ахуйн чиглэлийн хувийн хэвшил, аж ахуйн нэгж, ус

ашиглагчдын н хоршоо зэрэгтэй усалгаагаар хангах, ус зайлуулах, гидротехникийн байгууламжийг засварлах зэрэг харилцан ажиллагааг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлнэ.

Бүгд Найрамдах Киргиз Улсын усны нөөц, түүний ашиглалт, зохицуулалтын талаарх хууль тогтоомж Бүгд Найрамдах Киргиз Улсын “Усны тухай хууль” 2004 оны 12 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан ба 2013 оны 10 дугаар сарын 26-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орсон байна. Энэ хуульд усны нөөц ашиглалт, бохирдлоос хамгаалах болон хамгаалалтын бүсийг тогтоох болон усны удирдлагын асуудлын зохицуулалтын талаар тусгасан ба “Газрын доорх усыг хамгаалах тухай” журмыг Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 18-ны 31 дүгээр тогтоолоор баталсан байна. Энэхүү журмаар газрын доорх усыг ашиглах, хамгаалах харилцааг зохицуулдаг. Бүгд Найрамдах Киргиз Улсын нутаг дэвсгэр дэх усны нөөцийн байдал, ус ашиглах үйл ажиллагааны горим болон усны хамгаалалтын тусгай арга хэмжээг хянахын тулд хоёр төрлийн хяналтын систем үүсгэж ажиллуулдаг. Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй нөлөөллийг харгалзан үзэж бүс нутаг бүрийн гүний усны (гидрогеологийн усан сангууд) болон усны өөрчлөлтийн зүй тогтлын нэгдсэн мэдээллийг авах зорилгоор бүсийн ажиглалтын сүлжээ бий болдог. Мөн ус бохирдуулж болзошгүй үйл ажиллагаа явуулдаг субъектүүдийг хянахын тулд тусгай ажиглалтын сүлжээ байгуулдаг.

Тусгай ажиглалтын сүлжээ нь (заавал байх бүрэлдэхүүн хэсэг) усны хэрэглээний тоноглол барилгын ажил (сэргээн босголт, өргөтгөл) зэрэг төслүүдийн бүрэлдэхүүнд ордог. Тусгай ажиглалтын сүлжээ нь юуны өмнө дүүргийн аж үйлдвэр, хөдөө аж ахуй болон ахуйн гадаргуун ус зайлуулах болон хог хаягдлыг хадгалагч (хаягдлын цөөрөм, лагтын коллектор, тунгаах сав, ууршуулагч цөөрөм, үнсний овоолго болон бусад хог хаягдал хадгалагч тусгай газрууд) мөн газар доорх газрын тос, тосны бүтээгдэхүүн ба шингэрүүлсэн хий хадгалагч, бүх томоохон аж үйлдвэр, хөдөө аж ахуйн объектуудад тоноглогдсон байх ёстой. Аж үйлдвэр болон бусад объектуудын ажиглалтын сүлжээ, дизайн, тоног төхөөрөмж, ажиглалт болон лабораторийн хяналтыг “Киргизийн гидрогеологийн нэгдсэн экспедиц” төрийн байгууллагын удирдамжийн дагуу ус хэрэглэгчдээр гүйцэтгүүлдэг. 57 1995 оны 1-р сарын 25-ны өдөр Киргизийн Засгийн газрын 19 тоот тушаалаар батлагдсан Бүгд Найрамдах Киргиз Улсын Усны хэрэглээний улсын бүртгэл, хяналтыг зохицуулах журмын дагуу улсын бүртгэлийг хөтлөх, усны ашиглалтыг хянах журмыг тогтоосон. Төрийн усны бүртгэлийн үндсэн зорилго нь усны тоо хэмжээ, чанар, мөн гүний усны батлагдсан нөөц илэрсэн орд газрын хүрээнд хэрхэн ашиглагдаж буй болон цаашид хүн ам, үйлдвэрлэл ба бусад байгууламжуудын хэрэгцээнд хэрхэн үр өгөөжтэй ашиглагдах талаар мэдээлэл авах зорилготой. Улсын нэгдсэн системээр төрийн усны бүртгэл болон ашиглалт хэрэгждэг. Харин “Гүний ус” гэсэн хэсэг нь уул уурхайн салбарын хөгжил болон газрын хэвлий ашиглалтад төрийн бодлого хэрэгжүүлдэг эрх бүхий байгууллагаар, “Гадаргын ус” (усны тогтоц үүсэх бүсийн гадаргын ус) гэсэн хэсэг нь ус цаг уурын салбарын төрийн эрх бүхий байгууллагаа, харин “Гүний болон гадаргын усны ашиглалт” гэсэн хэсэг нь усны нөөцийн салбарт төрийн бодлого хэрэгжүүлдэг эрх бүхий байгууллагаар хэрэгждэг байна. Эрх бүхий төрийн байгууллага нь уул уурхайн салбарын хөгжил болон газрын хэвлий ашиглалтад төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд:

- гүний усны нөөцийн улсын бүртгэл хийхээс гадна тэдний чанар болон горимыг хянадаг;

- бүс нутгийн болон тусгай ажиглалтын сүлжээгээр нөөцийн хомсдол үүсэж, чанар нь муудаж болзошгүй бүс нутгууд дахь гүний усны төлөв байдлыг хянаж, судалдаг;

- гүний усны талаар сонирхсон байгууллагууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийг мэдээллээр хангадаг. Эрх бүхий төрийн байгууллага нь усны нөөцийн салбарт төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд:

- ус ашиглалтын төрийн хяналт болон бүртгэлийг хийнэ;

- ус хэрэглэгчдийн бүртгэл болон тайланг гаргана;

- усны менежментийн тоноглолын жагсаалт гаргана. Эрх бүхий төрийн байгууллага нь ус цаг уурын салбарт:

- усны тогтоц үүсэх бүсийн гадаргын усанд төрийн усны бүртгэл явуулдаг

- ус цаг уурын станц, шуудангийн системд ажиглалт хийсний үндсэн дээр гадаргын усны хяналт хийдэг

- усны тоон үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг урьдчилан таамаглах боломжийг олгодог. Бүгд Найрамдах Киргиз Улсын “Газрын хэвлийн тухай” хууль 2018 оны 5 дугаар сарын 19-ний өдөр нэмэлт, өөрчлөлт орж, шинэчлэгдсэн байна. “Газрын хэвлийн тухай” хуульд газрын доорх цэвэр болон эрдэст усыг ашигт малтмал гэж тодорхойлж авч үзсэн байна. Хуулийн 45 дугаар зүйлд 30 метрээс дээш гүнтэй худагтай эсвэл 30 метрээс дээш өрөмдөж ус хэрэглээний худгийг /водозаборных скважин/ гаргасан бол өрөмдлөг дууссанаас 30 хоногийн дотор цооногийн техникийн үзүүлэлтийн талаар газрын хэвлийг ашиглах эрх бүхий төрийн байгууллагад мэдэгдэх шаардлагатай. Энэ байгууллага нь улсын бүртгэлд бүртгэнэ. Үүнийг зөрчсөн тохиолдолд Захиргааны хариуцлагын тухай хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын усны нөөц, түүний ашиглалт, зохицуулалтын талаарх хууль тогтоомж БНХАУ-ын Ардын Их Хурал нь усны нөөц, түүнийг ашиглах, ус бохирдохоос урьдчилан сэргийлэх, хянах тухай болон үерийн эрсдэлийг зайлуулах тухай зэрэг үндэсний хэмжээний хууль тогтоомжийг баталдаг. Үндэсний хууль тогтоомжид зааснаар Төрийн Зөвлөл нь Хятадын усны менежментийг хэрэгжүүлэх, удирдан зохицуулах дээд байгууллага байхаар хуульчлан тогтоосон байна. БНХАУ нь Усны тухай хуулиа 1988 онд баталж, 2002 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд тус хуульд усны нөөцийн менежментийг нэгдмэлээр авч үзэхээр тусгасан байна. Тодруулбал, уг хуульд усны хуваарилалт, ус олборлолт, ашиглах эрх, голын сав газрын менежмент, усны хэрэглээний үр ашиг, хамгаалал, бохирдлоос сэргийлэх, нөөцийг хамгаалах зэрэг заалтуудыг хуульчлан тогтоожээ. Тус улсын Засгийн газраас усны нөөц хамгаалал, усны нөөцийн тогтвортой хэрэглээг бий болгох замаар хөгжлийг түргэсгэхтэй холбоотой тэргүүлэх ач холбогдол бүхий бодлогын баримт бичгийг 2011 онд баталсан.

Уг баримт бичгээр ус хэрэглээ, ашиглалтын үр дүнтэй байдлыг сайжруулах, хянах, усны бохирдлын зохицуулалт хийх, хариуцлагын тогтолцоог сайжруулах,

усны менежментийг дээд түвшинд хүргэхэд чиглэсэн төлөвлөгөөг баталсан юм. Үүнтэй холбоотойгоор Засгийн газрын зүгээс усны асуудал хариуцсан байгууллагуудын бүтцийг сайжруулах, усны менежментийг зах зээлд суурилсан аргаар зохицуулах тал дээр анхаарал хандуулж байна. Жишээлбэл, 2013 онд Үндэсний Хөгжлийн Шинэтгэлийн Хороо (NDRC), Сангийн Яам, Усны нөөцийн яам хамтран усны төлбөрийн талаарх нэгдсэн удирдамж гаргаж, тэр ондоо хот суурин газрын усны үнэлгээний шинэчилсэн аргачлалыг боловсруулсан байна. Энэ аргачлалын дагуу бүх хот, суурин газрын айл өрхүүдийн усны хэрэглээнд тулгуурласан гурван шатлалтай төлбөрийн систем бий болгож, 2015 оны сүүлээс мөрдөж эхлээд байна. БНХАУ-ын усны асуудал хариуцдаг төрийн төв байгууллагуудын бүтэц, чиг үүргийг авч үзвэл,

(1) гадаргын болон газрын доорх усны менежмент, голын сав газрын менежмент, үерийн хяналт, ус, хөрсний хамгааллын асуудлыг Усны нөөцийн яам хариуцан усны нэгдсэн бодлого, төлөвлөлт хийх, нөөцийг хамгаалах, үер, ус, хөрс хяналтыг хэрэгжүүлдэг,

(2) Бохир усны цэвэрлэгээ, бохирдлоос урьдчилан сэргийлэх чиг үүргийг Байгаль орчны яам хэрэгжүүлж усны сав газар, түүний бүсийг хамгаалах, үндэсний хэмжээнд усны чанарын болон бохир ус цэвэрлэгээний стандартыг бий болгох үйл ажиллагааг явдаг,

(3) Хот суурин, аж үйлдвэрийн усны хангамж, хэрэглээ, ус зайлуулах шугамын асуудлыг Орон сууцны болон хот хөдөөгийн хөгжлийн яам хариуцаж, усан хангамж болон бохир ус татан зайлуулах төслүүдийн менежмент, төлөвлөлт, барилга байгууламжтай холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлдэг бол

(4) Хөдөө аж ахуйн ус ашиглалт, загасны аж ахуйн усан хангамжийн асуудлыг Хөдөө аж ахуйн яам хариуцаж хөдөө аж ахуйд хэрэглэсэн усны бохирдлын эх үүсвэрийн хяналт, загасны аж ахуйн усан сан бүхий газрын хамгаалах хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байна. Харин дээрхээс гадна усны нөөцийг хамгаалах зорилгоор ойн санг хамгаалах чиг үүргийг Ойн газар, усан цахилгаан станц барих, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг Цахилгаан эрчим хүчний 59 корпорац, Усны нөөц болон экосистемийг хамгаалах төлөвлөлтөд оролцож хөдөө аж ахуй, ой, усны нөөцийн менежмент бодлого төлөвлөлтийг зохион байгуулах чиг үүргийг Үндэсний шинэчлэл, хөгжлийн комисс, Гол мөрөн дээр зорчиж буй усан онгоц ус бохирдуулж байгаа эсэхэд хяналт тавих чиг үүргийг Зам, тээврийн яам, Ундны усны стандартын менежментийг хэрэгжүүлэхэд Эрүүл мэндийн яам тус тус оролцож хууль, тогтоомж, дүрэм журмын хүрээнд тодорхой үйл ажиллагааг явуулдаг байна.

Ийнхүү Усны менежменттэй холбоотой чухал асуудлуудыг хуульдаа тусгасан боловч хэрэгжилт нь Засгийн газраас хэт хамааралтай, шаталсан, нүсэр бүтэцтэй, Засгийн газрын агентлагуудын чиг үүрэг давхардсан, зохицуулалт дутмаг зэргээс шалтгаалан усны менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэл үүсээд байгаа талаар Хятадын судлаачид эрдэм шинжилгээний өгүүлэлдээ дурдсан байгаа нь манай оронд үүсээд буй бэрхшээлтэй нэгэн адил байна. БНХАУ-ын усны удирдлагыг хэрэгжүүлэгч байгууллагуудыг авч үзвэл:

1) Төрийн Зөвлөл;

2) Усны асуудал хариуцсан хороо;

3) Усны нөөцийн яам болон Байгаль орчны яам;

4) Яамны харьяа газар, хэлтсүүд гэсэн бүтэцтэй байна. Харин Байгаль хамгаалах тухай хуулиар ус бохирдуулсантай холбогдох харилцааг зохицуулдаг бөгөөд ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хаягдал усны эзлэхүүн болон стандартаас давсан бохирдуулах бодис тус бүрийн агууламжаас хамааруулан нөхөн төлбөр тооцохоор заасан байдаг байна. Хятад улсад үндэсний болон орон нутгийн түвшинд мөрдөгдөх хаягдал усны стандарт өөр өөр байх бөгөөд орон нутгийн түвшинд хаягдал усны стандарт нь үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, үйлчилгээний газрын үйл ажиллагааны төрөл онцлогоос хамааруулан үндэсний стандартад тусгагдаагүй бодисын төрлүүд болон тэдгээрийн зөвшөөрөгдөх дээд агууламжийг илүү хатуу тогтоож өгдөг. Хятадын Засгийн газарт шууд харьяалагдах 34 мужтай ба Бээжин, Шанхай, Тяньжин, Чунцин хотуудын захиргаа нь мужийн захиргаатай ижил эрх мэдэлтэй байна. Бээжин хотын усны менежмент бүтцийн хувьд Хятадын бусад муж, хотуудаас ялгаатай бөгөөд хэдэн жилийн өмнөөс ус хангамж, усны менежмент, эрүүл ахуйтай холбоотой засаглалын бүтцээ өөрчлөн зохион байгуулсан. Одоо байгаа Бээжингийн Усны Хэрэг Эрхлэх Газар (Beijing Water Authority) нь усны асуудал хариуцсан өмнөх яам, агентлагуудаас илүү үр дүнтэй ажиллаж байна.

Бүгд Найрамдах Франц Улс

Бүгд Найрамдах Франц Улсад анх 1964 онд усны нөөц ашиглалт, түүний менежментийн цогц зохицуулалтыг агуулсан Усны тухай хуулийг баталсан байна. Уг хуулийн гол үзэл баримтлал нь усны сав газрын удирдлага, бие даасан менежмент загвар байсан. Энэхүү Усны тухай хуулиар усны менежментийн дараах суурь гурван зарчмыг бий болгожээ. Үүнд:

- Томоохон голын сав газрууд бие даасан менежменттэй буюу өөрийн удирдлагатай байх;
- Усны асуудал хариуцсан Төрийн захиргааны байгууллага, усны нөөц ашиглагч, хэрэглэгч болон орон нутгийн засаг захиргааны байгууллагын төлөөллөөс бүрдсэн Усны зөвлөл байгуулж, хамтарсан удирдлагыг хэрэгжүүлэх;
- Усны нөөц болон чанарын менежментийг хэрэгжүүлж, санхүүгийн урамшууллын хэлбэрүүдийг нэвтрүүлэх.

Францын усны менежментийн системийг Европын улс орнууд суурь зарчим, жишиг тогтолцоо, хөгжлийн хандлага болоход тус хууль ихээхэн нөлөө үзүүлсэн. Франц улс 1992 онд Усны тухай хуулиа шинэчлэн баталж, усны эх үүсвэр, усны нөөц гэсэн ойлголтыг нарийвчлан усан сан бүхий газрын 61 экосистемийг менежменттэйгээр ашиглуулах бодлого баримталж эхэлсэн. Мөн 10-15 жилийн хугацаатай “Усны менежментийн мастер төлөвлөгөө”-г сав газар бүрээр гарган хэрэгжүүлж, усны нөөцийг эдийн засгийн нэг нөөц гэж үзэж бизнес төлөвлөлтийн аргачлалыг усны нөөц ашиглалтын салбарт оруулж ирсэн нэг чухал алхам болсон байна. Харин 2000 онд “Усны удирдлагын тогтолцоо”-г бий болгож, 2004 онд тус тогтолцоог дэмжих тухай хууль буюу “Усны менежментийн тухай” хуулийн баталсан. Тус хуулиар 2015 он хүртэлх усны нөөцийг хамгаалах бодлого боловсруулах, хяналт үнэлгээ хийхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, усыг зохистой хэрэглэсэн

хэрэглэгчдэд усны татвар, төлбөрийн тодорхой хувийг буцаан олгох зарчим бий болгосон, мөн аюултай, хортой бодисын бохирдлыг бууруулах, бүрмөсөн арилгах талаарх зохицуулалтыг хуульчилсан байна.

Үүний зэрэгцээ уг хуулиар бус нутгийн усны агентлаг бүр нийтээр дагаж мөрдөх “Усны менежментийн мастер төлөвлөгөө” болон түүнд нийцүүлэн тус бүрийн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх “Усны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, хэрэгжүүлэхээр тусгасан нь усны менежментийг шинэ шатанд гаргажээ. Франц улсын усны бодлогыг Засгийн газар, орон нутгийн засаг захиргааны байгууллага, ус ашиглагч иргэдийн төлөөллийн хамтын хэлбэрээр хэрэгжүүлдэг. Харин усны удирдлагын тогтолцоог үндэсний хэмжээний, сав газрын болон орон нутгийн гэсэн үндсэн гурван түвшинд авч үздэг. Үндэсний хэмжээнд Ерөнхий сайдын дэвшүүлсэн парламентын гишүүн Усны үндэсний зөвлөлийг удирдах бөгөөд зөвлөл нь усны үндэсний бодлого болон усны талаарх хууль тогтоомж боловсруулахад зөвлөгөө өгч, тэдгээрийг хэрэгжүүлэх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд саналаа өгч ажилладаг. Энэхүү зөвлөл нь яамны усны асуудал хариуцсан албан хаагчид, экспертүүд, орон нутгийн засаг захиргаа, ус хэрэглэгч, ашиглагч байгууллагын төлөөлөл болон Сав газрын хорооны ерөнхийлөгчдөөс бүрддэг байна. 2006 оны Усны тухай хуулиар тус зөвлөлийн цар хүрээг тэлж усны үнэ, нийтийн ус хангамж, бохирын шугамын үйлчилгээ, загасчлал, усны мэдээллийн систем хариуцсан дэд хороог байгуулсан. Орон нутгийн түвшинд баримтлах гол хууль тогтоомж нь 2000 оны 10 дугаар сард батлагдсан “Усны менежментийн тогтолцоо” гэсэн баримт бичиг бөгөөд үүнд усны бодлого, усны менежментийг хэрэгжүүлэхдээ Усны агентлаг бүр Голын сав газрын хороо байгуулахаар заасан байна. Тус хороо нь тухайн орон нутгийн удирдлагын төлөөлөл (40%), ус ашиглагч холбогдох байгууллага, иргэдийн төлөөлөл (40%), Засгийн газрын төлөөллөөс (20%) бүрддэг болно. Голын сав газрын хороо нь Усны хөгжил, менежментийн мастер төлөвлөгөө боловсруулж Засгийн газарт оруулдаг. Мастер төлөвлөгөөнд сав газрын усны менежментийн ерөнхий стратеги, зорилгууд тусгагдана. Усны нөөцөд нөлөөлж болох аливаа шийдвэр Мастер төлөвлөгөөтэй нийцсэн байх ёстой. Мастер төлөвлөгөөнүүд анх 1992 оны усны хуулийн дараа боловсрогдсон. Өнөөдөр Европын усны тогтолцооны удирдамжийн хүрээнд бүх төлөвлөгөө Голын сав газрын менежментийн төлөвлөгөө болж шинэчлэгдсэн.

Орон нутгийн түвшинд

- Цутгал гол, дэд сав газар, газар доорх усны ай сав
- Орон нутгийн усны хороод мастер төлөвлөгөөг хэрэгжүүлж, Усны хөгжил, менежментийн төлөвлөгөө боловсруулдаг. Орон нутгийн усны хороо нь орон нутгийн эрх бүхий байгууллага (50%), ус хэрэглэгчид, холбоод (25%), засгийн газрын (25%) төлөөллөөс бүрдэх бөгөөд орон нутгийн сав газрын олон нийтийн 62 байгууллага эсхүл бусад орон нутгийн бүлгүүдээр дамжуулан төлөвлөгөөгөө хэрэгжүүлдэг25. Тухайн орон нутагт усны бодлого, усны менежментийг хэрэгжүүлдэг Усны агентлаг нь ус бохирдуулсны төлбөр, бохир усыг цуглуулж, цэвэрлэсний төлбөр зэргээс санхүүждэг. Бичиг хэргийн болон удирдлагын зардалд зарцуулах маш бага хэмжээний татаасыг улсын төсвөөс татаас авдаг. Агентлагуудын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, санхүүжилтийг усны

агентлагуудын захирлуудын зөвлөлөөс бэлтгэж, сав газрын хороодоор батлуулан Ерөнхий сайд зөвшөөрсний дагуу таван жилийн хөтөлбөрөөр баталдаг.

Агентлаг нь ус хэрэглэгчид болон ус бохирдуулагчдаас цуглуулсан мөнгөн хөрөнгийг ус цэвэршүүлэх, усны нөөц болон экосистемийг хамгаалах, усны бодлого болон менежментийн талаар судалгаа шинжилгээ хийхэд захиран зарцуулдаг байна. Үүнээс гадна Усны агентлаг нь дараах үйл ажиллагааг эрхэлнэ:

- Тогтвортой усан хангамжийг бий болгох буюу усны нөөцийн хэрэглээнд хяналт тавих;
- Усны зохистой хэрэглээг бий болгосон, ус болон түүний экосистемийг бохирдлоос хамгаалж, нөхөн сэргээсэн тохиолдолд мөнгөн урамшуулал олгох;
- Гадаргын усны бохирдлыг хянах, гүний усыг бохирдлоос хамгаалах;
- Үер болон далайн түвшнийг хянах;
- Усны экосистем бүхий газрыг бохирдлоос хамгаалах, нөхөн сэргээх;
- Хур тунадасны усыг нөөцлөх, хадгалах арга хэрэгслийг бий болгох, дэмжих замаар гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх;
- Амралт, зугаалгын бүс бий болгож, тохижуулах зэргээр голын сав газрыг зохистой хэлбэрээр ашиглах, хөгжүүлэх. Франц улсад 1964-2015 онд усны нөөц ашиглахтай хэд хэдэн томоохон хууль тогтоомж батлагдсан нь Францын нутаг дэвсгэрийг 6 том голын сав газарт хувааж, эдгээрийг хариуцсан усны агентлагуудыг байгуулан ажиллаж байна.

Нидерландын Вант Улс

Нидерландын Вант Улсын усны нөөц, түүний ашиглалт, зохицуулалтын талаарх хууль тогтоомж Нидерланд Вант Улсад төрийн болон орон нутгийн засаг захиргааны дэргэд бие даасан, бүрэн эрх бүхий 23 усны газар (Water authority) ажилладаг. Эдгээр усны газрууд нь төрийн харьяа, төвлөрсөн бус, санхүүгийн хувьд бие даасан байгууллага бөгөөд бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Нидерланд улсын усны удирдлагыг хэрэгжүүлэх тогтолцоо нь

(1) Европын холбоо,

(2) тус улсын Засгийн газар,

(3) тус улсын 12 мужийн Засгийн газар,

(4) хотын захиргаа/393/ ба бүс нутгийн Усны газар/23/ гэсэн шаталсан бүтэцтэй байна. Тус улс нь онцгой бүс газруудад газар ашиглах төлөвлөгөө, менежментийн арга хэмжээг боловсруулж, тухайн бүс нутгийн хамгаалах, экосистемийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр байгалийн нөөц ашиглалт, олборлолт болон тухайн сав газарт нэвтрэх зочныг хязгаарлах зэрэг үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхийг хуулиар хүлээн зөвшөөрсөн байдаг байна. Харин судалгаа, шинжилгээ, танин мэдэхүйн чиглэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулахыг дэмждэг. Бүс нутгийн усны газрууд нь үерийн аюулгүй байдал, усны нөөц, чанарын менежмент, хот суурин газрын бохир ус цэвэрлэгээ, үерийн хамгаалалт, усан зам зэрэг усны менежменттэй холбоотой үйл ажиллагааг бүхэлд нь хариуцан ажилладаг байна. Ингэснээр бүс нутаг бүрд өөр өөр асуудал хариуцдаг олон байгууллага ажиллаж байсан хуучин тогтолцоог халж, усны асуудал хариуцсан байгууллагуудын мэргэжлийн ур чадвар, ил тод байдлыг нэмэгдүүлж чаджээ.

Бүгд Найрамдах Ливи Улс

Бүгд Найрамдах Ливи Улсын усны нөөц, түүний ашиглалт, зохицуулалтын талаарх хууль тогтоомж Ливи нь 1965 онд анхны усны тухай хуулиа баталсан бөгөөд ус бол зайлшгүй хэрэгцээ гэж тодорхойлсон байсан бол 1982 онд дахин шинэчилж усны нөөцийг зохистой ашиглах, бүс нутагт дамжуулан ашиглах тухай дагалдах тушаал шийдвэрүүд олноор гаргажээ. Усны нөөцийг зохистой ашиглахтай холбоотой 1982 оны 790 дугаар тогтоолд газрын доорх усыг хомсдол, бохирдлоос хамгаалах асуудлыг тусгасан. Усны асуудлыг 2012 оноос Усны нөөцийн яам хариуцан ажиллаж байгаа бөгөөд өмнө усны асуудал хариуцаж байсан Усны ерөнхий газрыг уг яаманд багтаасан байна. Үүнээс гадна Хүрээлэн буй орчны ерөнхий газар усны зарим асуудлыг хамтран хариуцдаг. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа “Усны тухай” 1982 оны хууль нь 16 зүйлтэй бөгөөд Хөдөө аж ахуй, хүн амын ундны усанд гадаргын болон газрын доорх усыг ашиглахтай холбоотой асуудлыг зохицуулдаг бол 1982 онд батлагдаж 2003 онд өөрчлөлт орсон “Хүрээлэн буй орчныг хамгаалах тухай” хуулиар усны нөөцийг хамгаалах тухай талаарх хэм хэмжээг хуульчилсан байдаг.

Мөн ус нөөц ашиглалтын талаар хэд хэдэн бодлогын баримт бичигт тусгасан байдаг. Үүнд Үндэсний усны нөөцийн менежментийн стратеги 2000- 2025 он гэсэн баримт бичигт “Газар тариалангийн ус хэрэглээг үр ашигтай болгох, үйлдвэрлэлийн ус хэрэглээг бууруулах, ус хэрэглээний үнэ цэнэ бий болгох, эдийн засгийн эргэлтэд оруулах, усны тоо хэмжээ чанарын хяналтыг нэвтрүүлэх, Гадаргын усны нөөцийг ихэсгэж газрын доорх усны хэрэглээг хязгаарлах, Усны нөөцийн тухай баримт бичгүүд, тогтоолуудыг гаргах” чиглэлийн хүрээнд үйл ажиллагаа хийхээр заасан бол 2008 онд баталсан Тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрийн “Хүрээлэн буй орчны тогтвортой байдал” гэсэн 7 дугаар зорилтын хүрээнд “Усны нөөцийг зөв зохистой хүртээмжтэй байдлаар дахин хуваарилах, ногдуулах, усны нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, унд ахуйн усны хүртээмжийг сайжруулах” чиглэлээр хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэхээр тусгажээ. Бүгд Найрамдах Ливи Улс нь Усны нөөцийн ашиглалтын тухай хуульд усны менежментийг нарийвчлан хуульчилсан юм. Хуульд зааснаар усны нөөцийн менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх институт нь Усны ерөнхий газар байхаар хуульчилсан бөгөөд уг төлөвлөгөөг шинжлэх ухаанд суурилсан судалгаа, шинжилгээний үр дүнг түшиглэж улс орны бүхий л 64 нутаг дэвсгэрийн нөхцөл байдлыг үндэслэн боловсруулах ёстой гэж заасан байна. Тус хуулиар Гадаргын болон газрын доорх усны өмчлөгч нь Ливийн ард түмэн байна. 5 дугаар зүйлд ус ашиглах зөвшөөрлийг олон нийтийн усны асуудал эрхэлсэн байгууллагаас олгох бөгөөд усны нөөцөд хомсдол үүсгэлгүйгээр ашиглах хамгаалах тухай заасан.

Харин 6 дугаар зүйлд усны нөөцийг бохирдуулахыг хориглох, 7 дугаар зүйлд Газар тариалангийн хөгжлийн газрын зөвшөөрөлгүй худаг өрөмдөхийг хориглох тухай болон тус газар нь ашиглагдахгүй байгаа худгуудыг хурааж авах, мөн усны газрын эрх үүргийг гүйцэтгэх буюу ашиглаж байгаа худгийн үйл ажиллагаанд үндэслэн хаах боломжтой гэх мэт давхардсан үүргүүдийг заасан байна. Хуульд усны нөөцийг ашиглах лиценз авах шаардлагуудыг тусгасан. Мөн 8 дугаар зүйлд усны нөөцийн хэрэглээнд хязгаарлалт хийх тухай, 10 дугаар зүйлд нэг эх үүсвэрээс олон хэрэглэгч хэрэглэх тохиолдолд гарах харилцааг зохицуулах тухай заасан. 11

дүгээр зүйлд усны нөөцийг бохирдуулахыг хориглох тухай заажээ. Бохирдлыг хянах, урьдчилсан сэргийлэх арга хэмжээг усны асуудал эрхэлсэн засгийн газрын байгууллага болон бусад хүрээлэн буй орчны болон бохирдуулах боломжтой салбарын асуудал эрхэлсэн байгууллагууд эрхэлдэг байна. Усны эх үүсвэрийг бохирдуулах үйл ажиллагааг хориглох эрх нь уг байгууллагуудад байдаг.

Хүрээлэн буй орчныг хамгаалах тухай хуульд /4 ба 42, 50 дугаар зүйл/ зааснаар Усны нөөц бол Ливийн ард түмний өмч бөгөөд Усны нөөцийг хэрэглэж байгаа хүн бүр түүнийг хамгаалах арга хэмжээг авах ёстой. Усны нөөцийг зохион байгуулах үүрэгтэй төрийн захиргааны төв байгууллага нь шинжлэх ухааны үндэслэлтэйгээр усны нөөцийг зөв зохистой хэмнэлттэй ашиглах үйл ажиллагаагаар хангаж ажиллана. Хүрээлэн буй орчныг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага нь усны нөөцийг бохирдлоос хамгаалах, хянах үүрэг хүлээх бөгөөд уг чиг үүргийг хэрэгжүүлэхдээ уг хуулийг дагаж гарах дүрэм, журмыг боловсруулах, усан сан бүхий газарт хэрэгжүүлэх төслүүдийн хүрээлэн буй орчинд нөлөөлөх байдлыг судлах, Усны нөөцийг бохирдлоос урьдчилан сэргийлэх талаар импорт, үйлдвэрлэл, тээвэр болон бусад химийн бодисын хэрэглээн дээр зөвлөмж гаргаж холбогдох байгууллага, иргэдэд хүргүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр дээрх хуульд заасан байна.

Израйл Улс

Израйл Улсын усны нөөц, түүний ашиглалт, зохицуулалтын талаарх хууль тогтоомж Израйл улс нь Усны хуультай бөгөөд тус хуулиар газрын гадаргын болон доорх усыг усны нөөцөд хамтатган авч үзэж ерөнхий заалтуудаар зохицуулсан байна. Усны нөөцийн хэрэглээ болон бохирдлоос урьдчилан сэргийлэх талаарх зохицуулалтыг уг хуульд илүүтэйгээр тусгасан бөгөөд уг хуулийг дагалдан гарсан тогтоол, шийдвэрээр бусад холбогдох харилцааг нарийвчлан зохицуулж байна. Тухайлбал, Ус ашиглагчдад олгох зөвшөөрлийн тухай Засгийн газрын тогтоол /2012 он/, тогтоолыг хэрэгжүүлэх дүрэм журам, Худгаас ус олборлох ногдол хэмжээг тогтоох тухай Засгийн газрын тогтоол /2014 он/, Усны сав газрыг хамгаалах хөтөлбөрүүд, түүнчлэн Газар тариалангийн ус хэмнэх болон Уур амьсгалын дасан зохицох хөтөлбөрүүд зэрэг нь үүнд хамаарагдах юм. Эдгээр эрх зүйн актууд нь ус хэрэглээний эрэмбийг тогтоон ашиглах, Онцгой бүс нутгийг ус хэрэглээний бүсээс чөлөөлөх, усны 65 нөөцийн мэдээллийн сан бүрдүүлэх, Гадаргын усыг шүүрүүлэх сан байгуулах, Газар тариаланд хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, Газар тариаланд хэрэглэж байгаа усанд хэмжээ тогтоож уг хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд торгууль ногдуулах, Газрын доорх ус хэрэглээний хориглох бүсийг тогтоох Газрын доорх усны орд бий болгож усны нөөцийг хуримтлуулах зэрэг зохицуулалтыг нарийвчлан тогтоож холбогдох харилцааг зохицуулсан байдаг байна.

Харин Усны тухай хуулиар хуулиар усны нөөцөд гадаргын болон газрын доорх ус, дэвшилтэт технологиор бий болох усыг хамруулахаар хуульчлан усны нөөцийг хомсдолд оруулахгүйгээр ашиглах эрхтэй болохыг заасан. Мөн Усны нөөцийг эрэмбийн дагуу ашиглахаар заасан нь дэвшилттэй байх бөгөөд тухайн эрэмбийн

зорилгод ашиглах нөөц хүрэлцэхгүй үед дараачийн зорилгоор ашиглахыг хориглосон. Эрэмбийн тухайд,

(1) Унд, ахуйн ус хэрэглээ,

(2) Газар тариалан, хөдөө аж ахуй,

(3) Үйлдвэрлэл,

(4) Үйлчилгээ, худалдаа,

(5) Олон нийтийн үйлчилгээ,

(6) Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд (2004 оны нэмэлтээр орсон.) 2012 онд баталсан “Үндэсний усны салбарын мастер төлөвлөгөө 2050 он” гэсэн бодлогын баримт бичгээр усны талаарх гол гол чиглэл буюу 11 цэм сэдвийн хүрээнд хэрэгжүүлэх хэд хэдэн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон бөгөөд усны нөөцийн менежмент болон эрэлтийн менежмент асуудлыг тусгаж усны хэрэглээ, нөхөн сэргээлтийн төлөвийг тогтоожээ. Газрын доорх усны хэрэглээг багасгаж далайн усыг цэнгэгжүүлэн ашиглах технологийг нэмэгдүүлэх, бохир усыг дахин ашиглах, гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх тухай төлөвлөсөн байна. 9. Австралийн Холбооны Улсын усны нөөц, түүний ашиглалт, зохицуулалтын талаарх хууль тогтоомж Австралийн Холбооны Улсын усны нөөцийг менежментийн хувьд авч үзвэл үндэсний хэмжээний усны нөөцийг ашиглах, хянах буюу бодлогын шинжтэй асуудлыг Эзэн хааны Захиргаа шийдвэрлэдэг бөгөөд муж бүрийн Засгийн газрын харьяа Усны хэрэг эрхлэх газар нь ус ашиглах зөвшөөрлийг олгох ба усны өмчийн эрх (water property right)-ийн хүрээнд тодорхойлогдсон зарчмын дагуу зохицуулагдана.

Усны нөөцийг ашиглахдаа дараах эрэмбийг баримталдаг:

(1) Хүний унд, ахуйн хэрэгцээний ус,

(2) Байгаль орчныг тэтгэх, усыг сав газар хооронд дамжуулах,

(3) Усалгаатай газар тариалан, ахуйн хэрэглээ болон үйлдвэр аж ахуй. Австралийн Засгийн газрын 2004 онд NWI буюу Усны шинэчлэлийн үндэсний хэмжээний үндсэн баримт бичгийг баталсан бөгөөд Австралийн Засгийн газраас хэрэгжүүлэх усны менежмент, зохицуулалтад уг эрх зүйн акт гол үүрэг гүйцэтгэдэг. NWI нь анх 1994 онд Австралийн Засгийн газруудын зөвлөлөөс гаргасан Усны шинэчлэлийн тогтолцооны зөвлөмжөөс эхтэй бөгөөд тус баримт бичигт усны үр ашигтай бөгөөд тогтвортой ашиглалтын засаглалд хандах үндэсний нийтлэг хандлага бий болгох хэрэгцээ байгааг хүлээн зөвшөөрсөн юм. NWI-ийн гол зорилго нь хэт их хуваарилсан усны системийг тогтвортой түвшинд сэргээн тогтоох замаар усны ашиглалтын үр ашиг, бүтээмжийг сайжруулах, худалдааны саад тотгорыг арилгаж усны зах зээлийн хөгжлийн нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Энэ баримт бичгийн дагуу бүх муж 66 улс, нутаг дэвсгэрт нийтлэг багц зарчмуудтай нийцүүлэн ялангуяа экосистемийн байнгын, сөрөг өөрчлөлтийг хязгаарлах, хүний хэрэгцээнд зориулсан хангамжийн тодорхой бус байдлыг шийдвэрлэхийн тулд захиргааны болон хууль зүйн өөрчлөлтүүд хийж байна. Үүний зэрэгцээ Австралийн Засгийн газар 2007 оны Усны тухай хуулиар дамжуулан усны эрх зүйн зохицуулалт болон менежментэд хяналт тавьж байна. Марри-Дарлингийн (The Murray-Darling Basin) сав газарт тусгайлан зориулж гаргасан тус хуулиар засгийн газарт тодорхой усны нөөцийн төлбөр, худалдаа, зах зээлийн дүрмийг хянах эрх өгсөн.

Мөн уг хууль нь хэд хэдэн муж дамнасан усны нөөцийн ашиглалт хамгаалалтын талаар зохицуулсан байх бөгөөд энэ хуульд муж бүрд нэг нөөцөөс авах усны хүртээмжийг хуульчилж зааж өгснөөрөө онцлог. Усыг авч, ашиглах арга замд нөлөөлж болох Байгаль орчин ба биологийн төрөл зүйлийг хамгаалах тухай хуулийн (1999) дагуу Австралийн Засгийн газарт хязгаарлалт хийх тодорхой эрх мэдэл олгосон байдаг. Ус хэрэглэх эрх болон уугуул иргэдийн хууль ёсны эрхийн тухай хууль, Уугуул иргэдийн хууль ёсны эрхийн тухай хууль (1993) нь тухайн газар эсвэл усыг өмчлөх уугуул иргэдийн хууль ёсны эрхийг тогтоох механизмаар дамжуулан уугуул иргэд болон Торрес Стрэйт арлын уугуул оршин суугчдын эрх болон ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч, хамгаалдаг. Австралийн Холбооны Улс нь гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх тал дээр олон ажил хийхийн зэрэгцээ газар доорх усыг зохиомлоор нэмэгдүүлэх, далд нэвчүүлэх байгууламжуудыг усны нөөцийн менежментийн төлөвлөгөөнд тусгах чиг баримжааг сүүлийн жилүүдэд баримталж байгаа бөгөөд энэ нь байгаль орчин болон усны нөөцийн хамгаалах сэргээхэд чухал нөлөө үзүүлж байна.

Мөн Муж улсуудын “Усны тухай” хуульд усны нөөцийг ашиглах, хамгаалах ерөнхий зааltуудаар зохицуулсан байдаг. Австрали улс 2013 онд Үндэсний усны чанарын менежментийн стратегиа баталсан байна. Харин 1984 онд Усны агентлагийн тухай хуулийг баталж яам, усны нөөцийн удирдлагын хэрэгжүүлэх бүтэц, хэрэгжүүлэх байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээ, эрх үүргийг заасан байна. Муж бүр Усны агентлагийн тухай болон Усны нөөц ашиглах талаарх хуультай байдаг бөгөөд өөрийн гэсэн усны менежментийн бүтэцтэй. Гэсэн хэдий ч мужуудын Усны тухай хуулиудад нь нийтлэг зааltууд их байдаг.

Мароккогийн Вант Улс

Мароккогийн Вант Улс нь 1995 оны Усны тухай хуулийн хүрээнд усны нөөц ашиглах, хамгаалахтай холбоотой харилцаагаа зохицуулдаг бөгөөд уг хуульд нийцүүлэн холбогдох дүрэм, журам, төлөвлөгөөг боловсруулдаг байна. Энэ хуулиар тус улс нь усны үндэсний төлөвлөгөө байхаар заасан бөгөөд Засгийн газраас уг төлөвлөгөөг батлахаар заасан. Түүнчлэн, хуульд усны менежментийг сав газрын захиргаагаар дамжуулан хэрэгжүүлэхээр тусгасан байна. Томоохон усны сав газар бүр усны асуудал асуудал хариуцсан агентлаг байгуулах тухай тусгаж, түүний эрх зүйн статус, үүргийг зааж, санхүүгийн хараат бус байдлыг олгосон байдаг.

Сав газрын агентлаг нь Усны нөөцийг ашиглах талаарх хууль тогтоомжийг сахиулах буюу хэрэгжүүлнэ. Энэ усны эрх, зөвшөөрлийн бүртгэл хийх, гадаргын болон газрын доорх усны нөөц, чанарын хяналт шинжилгээ явуулах, ус олборлолтын зөвшөөрөл шинээр олгох, усны нөөц ашиглалтыг хянах зэрэг чиг үүргийг гүйцэтгэдэг байна. Мөн сав газрын агентлаг нь усны сав газрын менежментийг зохион байгуулах хүрээнд, усны үндэсний төлөвлөгөөтэй уялдсан сав газрын хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, бохирдлын болон 69 бохир ус зайлуулсны төлбөрийг хураж, бохирдлыг хянахад хөрөнгө оруулах, бохирдлыг хянах, усны нөөцийн болон үерийн менежментийг сайжруулахын тулд эрх бүхий гэрээт байгууллагад санхүүгийн тусламж үзүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс (ӨАБНУ)-ын 1998 оны Үндэсний Усны хууль (National Water Act, No. 36 of 1998) нь дэлхийн усны салбарын эрх зүйн түүхэнд хамгийн дэвшилтэт, цогц бөгөөд хувьсгалт шинж чанартай хуулиудын нэгд тооцогддог. ЮНЕСКО болон Олон улсын усны менежментийн хүрээлэнгээс үүнийг жишиг хууль хэмээн үнэлдэг.

1. Хуулиар зохицуулсан харилцаанууд ба зохицуулах хэлбэр

Тус хууль нь усыг байгалийн нэгдсэн эргэлт (hydrological cycle) гэж үзэж, дараах харилцааг цогцоор нь зохицуулдаг:

Усны өмчлөл: Хувийн өмчийн ус гэх ойлголтыг бүрэн устгасан. Газар доорх болон дээрх бүх усыг "Үндэстний нийтийн нөөц" гэж зарлаж, төр зөвхөн итгэмжлэгдсэн хадгалагч (Public Trustee) болохыг хуульчилсан.

Ус ашиглах эрх: Усыг өмчлөх биш, зөвхөн "ашиглах зөвшөөрөл" (License)-ийг хугацаатай олгодог. Зөвшөөрлийг олгохдоо нийгмийн тэгш байдал, эдийн засгийн үр ашиг, байгаль орчны тэнцвэрийг харгалздаг.

Усны бохирдол ба хамгаалалт: "Бохирдуулагч нь төлөх" зарчмыг хатуу баримтална. Бохирдуулсан этгээд өөрийн зардлаар нөхөн сэргээх бөгөөд усыг бохирдуулах эрсдэлтэй үйл ажиллагааг тусгай зөвшөөрлөөр хязгаарлана.

Усны санхүү, үнэ тариф: Усыг үнэгүй хэрэглэх уламжлалт хандлагыг халж, усны эх үүсвэрийг хамгаалах, дэд бүтцийг барих, усны үйлчилгээ үзүүлэхэд зохицсон шатлалт тарифын (Pricing Strategy) тогтолцоог хуульчилсан.

2. Хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүд

Хууль батлагдсанаас хойш практик шаардлагаар хэд хэдэн томоохон нэмэлт өөрчлөлтүүд орсон:

1999 оны Нэмэлт өөрчлөлт (Act 45 of 1999): Хуулийн зарим нэр томьёо, шүүхийн маргаан шийдвэрлэх (Усны трибунал)-тэй холбоотой зохицуулалтыг нарийвчлав.

2014 оны Нэмэлт өөрчлөлт (Act 27 of 2014): Байгаль орчны менежментийн нэгдсэн систем (NEMA)-тэй усны зөвшөөрөл олгох явцыг уялдуулж, хугацааг нь богиносгосон. Уул уурхайн салбарын ус ашиглалтад тавих байгаль орчны хяналтыг чангаруулсан.

Сүүлийн үеийн шинэчлэл (2024-2026 он): Уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүчний хямралаас шалтгаалан "Усны дэд бүтцийн үндэсний агентлаг" (South African National Water Infrastructure Agency)-ийг байгуулах тухай хуулийг баталж, усны томоохон байгууламжуудыг төвлөрүүлэн удирдах, санхүүжилтийг бие даан шийдвэрлэх өөрчлөлтийг хийсэн.

3. Хавсарсан хууль тогтоомж, дүрэм журам

Үндэсний Усны хууль (NWA) нь дараах хуулиудтай салшгүй холбоотойгоор хавсран хэрэгждэг:

Water Services Act (Усны үйлчилгээний тухай хууль - Act 108 of 1997): Хэрэглэгчдийг ундны усаар хангах, ариутгах татуургын үйлчилгээ, орон нутгийн захиргааны (хотын захиргаа) үүргийг зохицуулдаг (NWA нь байгалийн нөөцийг, харин энэ хууль нь крантны усыг зохицуулна).

National Environmental Management Act (NEMA - Байгаль орчны менежментийн хууль): Усны барилга байгууламж барихад байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (EIA) хийх суурь журмыг заана.

Дүрэм журмууд: "Ундны усны чанарын стандарт" (SANS 241), "Хаягдал усны стандарт журам", "Далангийн аюулгүй байдлын дүрэм журам" зэрэг салбарын сайдын тушаалаар батлагдсан багц дүрмүүд үйлчилдэг.

4. Тус хуулийн үзэл баримтлал (Concept)

Тус хуулийн гол үзэл баримтлал нь "Нийгмийн шударга ёс + Экологийн тогтвортой байдал" юм. Апартеидын (арьс өнгөөр ялгаварлах үзэл) дэглэмийн үед зөвхөн цагаан арьст газар өмчлөгчид усны давуу эрх эдэлдэг байсныг халж, усыг нийт ард түмний баялаг болгон өөрчлөх, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй усны нөөцийг үлдээхэд чиглэсэн хувьсгалт шинэчлэлийн концепцтой.

5. Үндсэн зарчим

Хуулийн тулгуур 3 үндсэн зарчим байдаг (Ингэлизээр 3E гэж товчилдог):

Equity (Шударга, тэгш байдал): Арьс өнгө, хөрөнгө чинээ үл харгалзан хүн бүр усыг тэгш хүртэх, ялангуяа урьд өмнө эрх нь зөрчигдөж байсан иргэдэд усны хүртээмжийг тэргүүн ээлжинд олгох.

Sustainability (Тогтвортой байдал): Ирээдүй хойч үедээ усны нөөцийг муутгалгүй өвлүүлэх, байгаль орчны өөрийгөө нөхөн сэргээх чадварыг алдагдуулахгүй байх.

Efficiency (Үр ашигтай байдал): Усыг эдийн засаг, нийгмийн хамгийн өндөр үр ашигтай салбарт зохистой хуваарилах, үрэлгэн байдлыг зогсоох.

6. Тус хуулийн онцлог

"The Reserve" (Нөөц усны тухай ойлголт): Дэлхийд анх удаа усыг хуваарилахдаа хамгийн түрүүнд хаана ч хөндөгдөшгүй "Нөөц"-ийг үлдээхээр хуульчилсан. Энэ нөөцөд:

Хүний суурь хэрэгцээний нөөц (хүн бүрд өдөрт хамгийн багадаа үнэгүй олгох 25 литр ус).

Экологийн нөөц (гол мөрөн, экосистемийг амьд үлдээхэд шаардлагатай усны доод хэмжээ). Энэ хоёрыг үлдээсний дараа л уул уурхай, хөдөө аж ахуйд ус ашиглах зөвшөөрөл олгодог.

Хувийн өмчийн усыг бүрэн халсан: Газрын доорх ус бол тухайн газар эзэмшигчийн өмч биш, улсын өмч гэдгийг маш тодорхой заасан.

7. Саарал усны зохицуулалт

Өмнөд Африк нь усны туйлын хомсдолтой улс тул саарал усыг хуулиар нарийвчлан зохицуулдаг.

Хуулийн Ерөнхий зөвшөөрлийн (General Authorisation) дагуу тодорхой хэмжээний саарал усыг (ариун цэврийн өрөө, гал тогооноос гарсан) гэр ахуйн нөхцөлд цэцэрлэг услах, жорлон угаахад тусгай зөвшөөрөлгүй ашиглахыг зөвшөөрдөг.

Гэхдээ үйлдвэр, уул уурхайн бохир болон саарал усыг заавал стандартын дагуу цэвэршүүлж, дахин ашиглах үүрэг хүлээлгэдэг бөгөөд байгальд шууд хаяхыг хатуу хориглож, хаясан тохиолдолд маш өндөр "Бохирдлын төлбөр" авдаг.

8. Усны менежментийн тогтолцоо (Байгууллагын чиг үүрэг)

Менежментийг 3 түвшинд хувааж, төвлөрлийг сааруулсан (Decentralized) зарчмаар ажиллуулдаг:

Үндэсний түвшин (Яам): Усны нөөц, ариун цэврийн байгууламжийн яам (DWS) нь бодлого боловсруулж, Үндэсний усны стратегийг тодорхойлно. сайд нь "Ерөнхий итгэмжлэгч" байна.

Бүс нутгийн түвшин (Catchment Management Agencies - CMA): Голын сав газрын агентлагууд. Энэ нь тухайн голын сав газарт усны зөвшөөрөл олгох, усны төлбөр хураах, хяналт тавих үндсэн үүргийг хэрэгжүүлдэг бие даасан байгууллага юм.

Орон нутгийн түвшин (Water User Associations - WUA): Ус ашиглагчдын холбоод. Фермерүүд, орон нутгийн иргэд хамтран усаа дундаа зохистой хуваарилах, суваг шуудуугаа засах зэрэгт хамтран ажиллах доод шатны нэгж.

9. Усны кодексийн бүтэц

Өмнөд Африкийн Үндэсний Усны хууль (Act 36 of 1998) нь дараах бүтэцтэй:

PREAMBLE (Удиртгал хэсэг)
CHAPTER 1: INTERPRETATION AND FUNDAMENTAL PRINCIPLES (Тайлбар ба үндсэн зарчим)
Definitions and interpretation (Тодорхойлолт ба тайлбар)
Purpose of Act (Хуулийн зорилго)
Public trusteeship of nation's water resources (Үндэстний усны нөөцийн нийтийн итгэмжлэл)
Entitlement to water use (Ус ашиглах эрх эдлэх)
CHAPTER 2: WATER MANAGEMENT STRATEGIES (Усны менежментийн стратеги)
Part 1: National water resource strategy (Үндэсний усны нөөцийн стратеги - Заалт 5-7)
Part 2: Catchment management strategies (Сав газрын менежментийн стратеги - Заалт 8-11)
CHAPTER 3: PROTECTION OF WATER RESOURCES (Усны нөөцийг хамгаалах)
Part 1: Classification system for water resources (Усны нөөцийн ангиллын тогтолцоо - Заалт 12)
Part 2: Classification of water resources and resource quality objectives (Усны нөөцийн зэрэглэл ба чанарын зорилтуудыг тодорхойлох - Заалт 13-15)
Part 3: The Reserve (Нөөц ус - Заалт 16-18)
Part 4: Pollution prevention (Бохирдлоос сэргийлэх - Заалт 19)
Part 5: Emergency incidents (Онцгой байдал, осол аваарийн үеийн зохицуулалт - Заалт 20)
CHAPTER 4: USE OF WATER (Усны ашиглалт)
Part 1: General principles (Үндсэн зарчим - Заалт 21-26)
Part 2: Considerations, conditions and essential requirements of general authorisations and licences (Зөвшөөрөл, лиценз олгоход анхаарах нөхцөл, шаардлагууд - Заалт 27-31)
Part 3: Existing lawful water uses (Урьд өмнө хууль ёсоор ашиглаж байсан усны хэрэглээ - Заалт 32-35)

Part 4: Stream flow reduction activities (Голын урсгал багасгах үйл ажиллагаа - Заалт 36)
Part 5: Controlled activities (Хяналттай үйл ажиллагаанууд - Заалт 37-38)
Part 6: General authorisations (Ерөнхий зөвшөөрөл - Заалт 39)
Part 7: Individual applications for licences (Лиценз авах хувь хүний өргөдөл - Заалт 40-42)
